

# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН

2020





## МЭНДЧИЛГЭЭ

# Закария Эл Марзуки,

Бадрах Энержи ХХК-ийн Гүйцэтгэх захирал

“ Цахилгаан эрчим хүчний хэрэглээ улам бүр нэмэгдсээр байгаа энэ цаг үед хүлэмжийн хийн ялгарлыг хязгаарлаж, нүүрстөрөгч бага ялгаруулдаг эрчим хүчний эх үүсвэрийг сонгох нь нэн чухал болоод байна. Энэ зорилтын үүднээс, байгалийн ураныг ашиглан нүүрстөрөгч бага ялгаруулдаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх нь дэлхийн дулааралтай тэмцэх шийдлийн нэгэн чухал хэсэг юм.

Монгол-Францын хамтарсан Бадрах Энержи компани нь Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт байрлалтай дэлхийн хэмжээний Зөөвч-Овоо, Дулаан-Уул ордуудыг ахисан шатанд хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэлхий нийтийн үйлсэд хувь нэмрээ оруулах зорилт тавин ажиллаж байна. Түүнчлэн бид төслөөрөө дамжуулан Монгол улсын эдийн засагт дорвитой хувь нэмэр оруулж, уул уурхайн экспортыг төрөлжүүлж, олон улсад Монгол улсын эзлэх байр суурь, нөлөөг бэхжүүлэхэд дэмжлэг болохыг эрмэлзэж байна.



Энэхүү тайлангаас Монгол улс болон дэлхийд эерэг нөлөө үзүүлэх арга зам хэмээн ойлгож болох компанийн нийгмийн хариуцлагын зарчим нь манай бизнес загвар болоод эрхэм зорилгод хэрхэн гүн гүнзгий тусгагдсаныг харах боломжтой. Ажилтнуудынхаа эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал болоод байгаль орчин хамгаалал, орон нутгийн иргэдийн сайн сайхны төлөөх зорилгоор хөтлөгдсөн стратегитэй уялдсан үйл ажиллагааныхаа талаар тус тайлангаар дамжуулан та бүхэндээ нээлттэй ил тод тайлагнаж байна.

Компанийн ололт амжилтанд чухал нэмэр оруулдаг ажилтнуудынхаа эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хамгаалах нь бидний эн тэргүүний зорилт юм. 2020 оны дунд үеийг хүртэл бид ажлын зогсолттой осолгүйгээр 1782 өдрийн туршид ажиллаж дээд амжилт тогтоолоо. Энэ нь хөдөлмөрийн аюулгүй байдлын хувьд нэн сайшаалтай, онцгой үр дүн билээ. Гэвч өнгөрөгч оны 6 дугаар сарын 13-нд Дулаан-Уул хээрийн ангийн засварын цехэд гэрээлэгч компанийн нэг ажилтан өдөр тутмын ажлаа гүйцэтгэх үедээ ажлын зогсолттой гэмтэл авсан. Азаар тухайн ослын зэрэг харьцангуй хөнгөн байсан ба гэрээлэгч компанийн ажилтан хэдхэн хоногийн дараа ажилдаа эргэн орсон. Энэхүү явдал нь өдөр тутмын ажлаа хийж гүйцэтгэж байх үедээ ч дээд зэргийн анхаарал сэрэмжтэй байх хэрэгтэйг дахин санууллаа. Цаашид энэ төрлийн ослыг гаргахгүй байх үүднээс үйл ажиллагааны цогц төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна.

2020 оны туршид COVID-19 цар тахлын нөхцөл байдал компанийн үйл ажиллагаанд үлэмж хэмжээгээр нөлөөлсөн хэдий ч оюутны тэтгэлэгт хөтөлбөр, малжуулах төсөл хийгээд сумын эрүүл мэндийн төвд эмнэлгийн тоног төхөөрөмж хандивлах зэрэг орон нутгийн иргэдэд ашиг тусаа өгөх нийгмийн төсөл хөтөлбөрөө үргэлжлүүлэн хэрэгжүүлээ. Түүнчлэн Улаанбадрах сум болон Зүүнбаян багийн Засаг дарга нартай байгуулсан Хамтын ажиллагааны гэрээг 2020 онд дахин нэг жилээр сунгасныг дурьдах нь зүйтэй. Тус хамтын ажиллагааны гэрээний хүрээнд компаниас хэрэгжүүлж ирсэн нийгмийн төсөл хөтөлбүүрдийг зохицуулан хэрэгжүүлж байгаа ба одоогийн байдлаар 2006 оноос хойш нийт 5.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг орон нутагт оруулаад байна.

Компанийн үйл ажиллагааны хувьд Монгол улсын холбогдох төр, засгийн байгууллагуудаас олгосон зөвшөөрлийн дагуу Зөөвч-Овоо туршилтын үйлдвэрийг 2011 оны Өмнөгийн туршилтаар гарган авсан урантай давирхайг боловсруулах ажлаар эхлүүлсэн ба энэхүү чухал үе шатыг амжилттай хэрэгжүүлж чадсандаа бид баяртай байна. 2021 онд Зөөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтын эхний торлол дээр уран олборлох ажлыг эхлүүлэх дараагийн чухал үе шатыг хэрэгжүүлэхээр манай хамт олон ажиллаж байна. Ингэснээр үйлдвэрлэлийн туршилт маань бүрэн утгаараа эхэлж чадах юм.

Таны гар дээр байгаа энэхүү тайлан маань манай компанийн нийгмийн хариуцлагын зорилт, үүрэг болон бахархуштай амжилтын талаарх бүрэн дүүрэн зураглалыг өгнө гэдэгт эргэлзэхгүй байна. Манай хамт олон хамтран ажиллагсдынхаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, хөршүүд, орон нутгийн ард иргэдийн сайн сайхан болон байгаль орчныг хамгийн өндөр түвшинд хамгаалж, уран олборлох төслийг хөгжүүлэх ажил үйлсээ үргэлжлүүлнэ гэдэгтээ бүрэн итгэлтэй байна.

# ОНЦЛОХ ТОО, БАРИМТ



ЗӨӨВЧ-ОВОО ОРДЫН  
ГЕОЛОГИЙН НӨӨЦ

**93,291** тонн



2006 ОНООС ОРОН НУТАГТ  
ОРУУЛСАН НИЙТ ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТ

**5,6** тэрбум төг



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТӨЛБӨРТ

**1,053,000,000**  
төг (жилд)



ХУДАЛДАН АВАЛТЫН

**97** хувийг

Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн  
нэгжүүдээс хийж байна



НИЙТ 86 АЖИЛТАНТАЙГААС

**96** хувь нь  
Монгол улсын иргэд

**24** хувь нь  
эмэгтэй ажилтнууд



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ ХЭРЭГЖИЛТИЙН  
ҮНЭЛГЭЭ

**90.1** хувь



2020 онд бүртгэгдсэн мэргэжлийн  
шарлагын хувийн тун

**0.10** мЗв/жил

Дэлхийн хүн амын жилд авдаг  
дундаж тун

**2.40** мЗв/ хүн



2010 ОНООС НИЙТ

**60** оюутанд

**140** удаагийн сургалтын  
тэтгэлэг олгов



2007 ОНООС

Малжуулах төсөлд нийт **115**  
малчин өрх хамрагдсаны

**84** нь Улаанбадрах сумаас  
**31** нь Зүүнбаян багаас хамрагдав

# АГУУЛГА

## БАДРАХ ЭНЕРЖИ ХХК 6

- Товч танилцуулга ..... 7
- Онцлох он дараалал ..... 7

## МАНАЙ ТӨСӨЛ 10

- Монгол Улсын эрчим хүчний талаар баримталж буй бодлого ..... 11
- Зөвөч–Овоо орд ..... 11

## КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ АРГА БАРИЛ 14

- Бадрах Энержи компанийн төслийн үндсэн оролцогч талууд .. 15
- Оролцогч талуудын хүлээлтийг таньж мэдэх ..... 15
- Түнш байгууллагууд ..... 16

## БИДНИЙ АМЛАЛТ, ҮҮРЭГ 17

## УГ ТАЙЛАНГИЙН ТУХАЙ 50

### 1 | ОРОН НУТГИЙН АРД ИРГЭД 18

- Ил тод байдал, зөвлөлдөх яриа хэлэлцээ ..... 19
- Нутгийн иргэдийн оролцоо ..... 20
- Ёс зүйн дүрэм ..... 24
- Ялгаварлан гадуурхах явдлыг мэдээлэх, гомдлоо гаргах ..... 24
- Санал гомдлоо гаргах, шийдвэрлүүлэх журам ..... 25
- Төлбөр тооцоон дах ил тод байдал ..... 25

### 2 | БАЙГАЛЬ ОРЧИН 26

- Байгаль орчин хамгаалал ..... 27
- Ус ..... 28
- Уур амьсгал ..... 29
- Эрчим хүч ..... 29
- Хог хаягдал ..... 29
- Биологийн олон янз ..... 33

### 3 | ХҮНИЙ НӨӨЦ 34

- Компанийн ажилтнууд ..... 35
- Орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь ..... 35
- Мэдлэгийн менежмент, ажилтнуудын сургалт, хөгжил ..... 36
- Хамтын гэрээ ..... 36
- Хөдөлмөрийн нөхцөлийн чанар ..... 37

### 4 | ЭРҮҮЛ МЭНД, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЦАЦРАГИЙН ХАМГААЛАЛТ 40

- Эрүүл мэнд ..... 41
- Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх ажиллагаа ..... 41
- Хөдөлмөрийн аюулгүй байдал ..... 42
- Цацрагийн хамгаалалт ..... 46

### 5 | ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭ 48

- Ханган нийлүүлэлтийн сүлжээн дэх үнэ цэн ..... 49
- Монгол Улсын ханган нийлүүлэгчдийг дэмжин ажиллаж байна ..... 49

# КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА



## Бадрах Энержи ХХК

Бадрах Энержи ХХК нь Дорноговь аймгийн нутагт нөөцөөрөө дэлхийд дээгүүрт орох Зөөвч-Овоо ураны ордын нарийвчилсан судалгааг хийж байгаа хариуцлагатай уул уурхайн компани юм. Монгол улсын ураны салбар дахь бусад төсөл хөтөлбөрөөс хамгийн дэвшилттэй явж буй төсөл бол Зөөвч-Овоо билээ.

Бадрах Энержи ХХК олон улсад шалгарсан шилдэг туршлага бүхий стандартыг мөрдөж, байгаль хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн салбарт сайн үзүүлэлттэй ажиллаж байна.

Бадрах Энержи ХХК нь Монгол Улсын төрийн өмчит Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компани болох "Мон-Атом" ХХК, Франц Улсын Орано Майнинг компанийн хамтарсан компани юм.

- 2 хувьцаа эзэмшигчийн түншлэл: Монгол улсын төрийн өмчит Мон-Атом ХХК, Франц улсын төрийн өмчит Орано групп
- Дулаан-Уул, Өмнөд, Зөөвч-Овоо ураны ордыг хамарсан ашиглалтын 3 тусгай зөвшөөрөл эзэмшдэг
- Монгол улс дахь хамгийн ахисан түвшинд явж байгаа ураны төсөл
- Нийт 86 ажилтны 96 хувь нь Монгол иргэд




### ОНЦЛОХ ОН, ДАРААЛАЛ

- 2013 ○ Зөөвч-Овоо ордын нөөцийг бүртгүүлсэн.  
Хувьцаа эзэмшигчдийн гэрээ байгуулав.
- 2015 ○ Зөөвч-Овоо төслийн ТЭЗҮ батлагдсан.
- 2016 ○ Ашиглалтын 3 тусгай зөвшөөрөл олгогдсон.  
Ашигт малтмал, газрын тосны газартай Орд ашиглах гэрээ байгуулав.
- 2017 ○ Мон-Атом ХХК хувьцаа эзэмшигч болов (34%).
- 2018 ○ АРЕВА Майнс ХХК нэрээ Бадрах Энержи ХХК болгож өөрчлөв.  
Дорноговь аймгийн Улаанбадрах сум, Сайншанд сумын Зүүнбаян багтай Хамтын ажиллагааны гэрээ байгуулав.  
Зөөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтын барилгын ажлыг гүйцэтгэсэн.
- 2019 ○ Зөөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтын барилгыг ашиглалтад хүлээн авав.
- 2020 ○ Зөөвч-Овоо ураны ордын батлагдсан нөөц 93,291 тн болж өсөв.
- 2021 ○ 7 дугаар сард Зөөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилт эхлэв.

## Бадрах Энержи ХХК-ийн хувьцаа эзэмшигчид

2013 оны 10 дугаар сард байгуулсан Хувьцаа эзэмшигчдийн гэрээ ёсоор:

- АРЕВА Монгол ХХК 66 хувийг,
- Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Мон-Атом ХХК 34 хувийг тус тус эзэмшиж байна.





## I Бадрах Энержи ХХК-ийн дийлэнхи хувьцаа эзэмшигч Орано групп

Цөмийн материалын салбарт хүлээн зөвшөөрөгдсөн Орано групп нь одоо ба ирээдүйд дэлхийн эрчим хүч болон эрүүл мэндийн салбарт тулгарах сорилтыг даван туулах шийдлийг боловсруулдаг. Орано групп нь салбарын мэдлэг туршлага, орчин цагийн дэвшилтэт технологийг бүрэн эзэмшсэн чадвартаа суурилж үйлчлүүлэгчдээ цөмийн түлшний бүтэн эргэлтийн бүх үе шатанд өндөр үнэ цэнэ шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангадаг. Цөмийн материалын хувиргалт ба хяналтад чиглэсэн ноу-хауг хөгжүүлэхээр ажиллаж буй Орано группийн 16,500 ажилтан дэлхийн уур амьсгал, одоо ба ирээдүйд байгалийн нөөцийг үр ашигтай зарцуулдаг дэлхийн төлөө мэдлэг, ур чадвараа зориулан аюулгүй байдлыг ханган, тасралтгүй инновацийг хөгжүүлэхээр шамдан ажиллаж байна.

### Уул уурхайн үйл ажиллагаа

Цөмийн түлшний бүтэн эргэлтийн анхны шат буюу Орано группийн уул уурхайн үйл ажиллагаа нь ураны эрэл хайгуул, үйлдвэрлэл болон ураныг дэлхийн зах зээлд нийлүүлэхэд чиглэдэг.

Орано групп нь Канад, Казахстан, Нигер улсад өртөгийн хувьд өрсөлдөх чадвартай уурхайдаа олборлолтын дэвшилтэт технологи нэвтрүүлсэн дэлхийн тэргүүлэх уран үйлдвэрлэгчдийн нэг юм.

16,500

Нийт ажилтны тоо

3,7 тэрбум евро

2020 оны нийт орлого

### Ораногийн гол үйл ажиллагаа



УУЛ УУРХАЙ



УРАНЫ ХИМИЙН БОЛОВСРЧУЛАЛТ, БАЯЖУУЛАЛТ



АШИГЛАСАН ТҮЛШНИЙ ДАХИН БОЛОВСРЧУЛАЛТ



ЦӨМИЙН ЛОГИСТИК



ТАТАН БҮҮЛГАЛТ, ХОЛБОГДОХ ҮЙЛЧИЛГЭЭ



ЦӨМИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛ

Хариуцлагатай уул уурхайн компанийн үүрэг хүлээсэн Орано групп нь үйл ажиллагаандаа хүн ам, хүрээлэн буй орчныг бүрэн хүндэтгэж, бүс нутаг, хүн амын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулан ажиллаж байна.

ОНЦЛОХ НЬ

Орано групп нь Испани улсын эрчим хүчний хэрэглээг бүрэн хангах хэмжээний ураныг нэг жилд үйлдвэрлэж байна. Ийм хэмжээний эрчим хүчийг нүүрснээс үйлдвэрлэвэл 240 сая тонн хүлэмжийн хийг нэмж ялгаруулах юм.

Орано Майнинг компани нь төрөлжсөн хөрөнгө, нөөцтэй байгаа нь удаан хугацаандаа баталгаатай ураны нийлүүлэлт авахыг хүсч буй аж ахуйн нэгжүүдэд уранаар найдвартай хангах нөхцөлийг бүрдүүлж байна.

Орано Майнинг компанийн ажилтнууд олон улс оронд ажилладаг бөгөөд түүний дотор Канад, Нигер, Казахстанд ураны олборлолт, үйлдвэрлэл явуулж байна.

### Орано майнинг хариуцлагатай уул уурхайн компани

Орано групп нь ураны олборлолтоор дэлхийд тэргүүлэгч компанийн нэг бөгөөд 2020 онд


6,529 тонн уран олборложээ

Компанийн стратегийн алсын харааны хүрээнд Орано Майнинг компани ажилчдынхаа дагаж мөрдөх үнэт зүйлсийг тодорхойлсон.

Орано групп нь хүний нөөц, олон талт байдал, цөмийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчин, ёс зүйн бодлогоороо дамжуулан үүрэг амлалтаа хэрэгжүүлдэг.

Хүний эрхийг хүндэлж, байгаль орчныг хамгаалахтай холбоотой ашиг сонирхол, тэдгээрийг зохицуулдаг хууль, дүрмийг биелүүлдэг бизнесийн үйл ажиллагаагаа зохион байгуулахад дээрх бодлого, дүрмээ ашиглана.

Орано групп нь үйл ажиллагааны үзүүлэлтээ бүх чиглэлээр сайжруулахыг тогтмол эрмэлзэхдээ группийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлж буй оролцогч талуудын хүлээлтийг харгалзан үздэг.







## I Монгол Улсын Засгийн газрын төлөөлөл Мон-Атом ХХК

Бадрах Энержи ХХК-ийн 34 хувийг Монгол улсын засгийн газар Мон-Атом ХХК-иар дамжуулан эзэмшиж байна. Дээрх хувьцааг Мон-Атом ХХК 2017 онд шилжүүлэн авснаар Бадрах Энержи ХХК Монгол-Францын хамтарсан компани болсон юм.

### Мон-Атом ХХК-ийн тухай

Мон-Атом ХХК нь Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 45 дугаар тогтоолоор “Уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмалын геологи хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд дангаар болон бусад хуулийн этгээдтэй хамтран оролцох, төрийн төлөөллийг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх” үндсэн чиг үүрэгтэйгээр 100 хувь төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан.

Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 4 дүгээр тогтоолоор Мон-Атом ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг Эрдэнэс Монгол ХХК-д шилжүүлж тус компанийн охин компани хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус компани нь өнөөгийн байдлаар БНФУ, БНЧУ, БНХАУ, ОХУ-тай цацраг идэвхт ашигт малтмалын геологи, хайгуул, олборлолтын төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн төлөөллийг зохих хуулийн дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.

## Компанийн удирдлага

### Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллагаа

Бадрах Энержи компанийн үйл ажиллагаа 2017 оны 6 дугаар сард ТУЗ-ийн анхны хурлаа хийснээр идэвхжсэн билээ. ТУЗ нь компанийн үйл ажиллагааны уялдаа холбоо, тасралтгүй байдлыг хангах үүрэгтэй юм. Монгол улсын Компанийн тухай хуулийн дагуу ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирлын чиг үүргийг хооронд нь зааглах шаардлагыг Бадрах Энержи компани үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш хэрэгжүүлж байна. Өнөөдөр төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Эрик Пакэ, гүйцэтгэх захирлын албан тушаалд 2021 оны 7-р сараас Марк Мелеард ажиллаж байна.

Бадрах Энержи компанийн дүрмээр ТУЗ-ийн зохион байгуулалт, үйл ажиллагаа ба эрх, үүргийг тодорхойлж өгсөн. ТУЗ жилд хоёроос доошгүй удаа хуралдаж, компанийн үйл ажиллагаатай холбоотой шийлдвэрүүдийг гаргаж байна.

### Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 9 гишүүнтэй:

- Эдгээрийн 6 гишүүнийг АРЕВА Монгол ХХК (Орано Майнинг компанийн салбар) өөрийн төлөөлөл болгон томилдог байна.
- Мон-Атом компанийг төлөөлсөн 3 гишүүнийг тухайн компаниас томилдог.

ТУЗ-ийн дэргэд Үйл ажиллагааны хороо, Аудитын хороо ажилладаг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн төлөөлөгчид нь Аудитын хороог жил жилээр ээлжлэн даргалдаг. Хороод жилд дөрвөөс доошгүй удаа хуралдаж, компанийн үйл ажиллагаа, санхүүг хэлэлцэж,

шаардлагатай тохиолдолд асуудлыг ТУЗ-д танилцуулан хэлэлцүүлж, зохих шийдвэрийг гаргуулдаг.

### Удирдлагын баг

Бадрах Энержи компанийн Гүйцэтгэх захирал удирдлагын багийг даргалдаг. Удирдлагын баг нь үйл ажиллагаа эрхэлсэн (үйлдвэрлэлийн туршилт, эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчин, компанийн нийгмийн хариуцлага, мэдээлэл, олон нийттэй харилцах) болон компанийн өдөр тутмын тасралтгүй, тогтвортой ажлыг (хүний нөөц, санхүү, хангамж, хууль, төр, засгийн байгууллагатай харилцах) хангадаг чиг үүргийн хэлтсийн захирлуудаас бүрддэг. Удирдлагын баг нь тогтмол хуралдаж, компанийн үйл ажиллагааг хэлэлцэж, шийдвэр гаргадаг.

- Гүйцэтгэх захирал
- Дэд захирал
- ХАБЭА, ТХОНХ эрхэлсэн захирал
- Зөвөч-Овоо Үйлдвэрлэлийн туршилтын техникийн асуудал эрхэлсэн захирал
- Санхүү эрхэлсэн захирал
- Хүний нөөц эрхэлсэн захирал
- Хуулийн асуудал эрхэлсэн захирал
- Гүйцэтгэх нарийн бичгийн дарга

Бадрах Энержи компани нь төвлөрсөн бус үйл ажиллагааны загварын дагуу ажилладаг. Өөрөөр хэлбэл, компанийн удирдлага, хяналтын чиг үүргийг компанийн төв оффисоос хэрэгжүүлдэг.

Компанийн удирдлагын баг Орано группийн ёс зүйн дүрэм болон тогтвортой хөгжлийн талаар компанийн хүлээсэн үүргийн биелэлтийг хангадаг.



# МАНАЙ ТӨСӨЛ





## Монгол Улсын эрчим хүчний талаар баримталж буй бодлого

### I Дэлхийн эрчим хүчний хөгжил

Цахилгаан эрчим хүчний хэрэгцээ улам бүр өсч, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэж байгаа өнөө үед нүүрс хүчлийн хий бага ялгаруулдаг эрчим хүч үйлдвэрлэх нь хүн төрөлхтөний гол зорилт болоод байна. 2050 онд дэлхийн эрчим хүчний хэрэгцээ хоёр дахин өсөхөд уур амьсгалын нөхөж үл болох өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэхийн тулд улс орнууд нүүрс хүчлийн хийн ялгаруулалтаа мөн хоёр дахин бууруулах шаардлагатай байгаа.

Цөмийн ба сэргээгдэх эрчим хүч нь дээрх зорилтыг хангах, харилцан дэмжлэг бүхий зохицол юм. Учир нь цөмийн цахилгаан станцын түүхий эд нь уран бөгөөд цөмийн болон сэргээгдэх эрчим хүч нь нүүрсхүчлийн хий бага ялгаруулдаг эрчим хүчний найдвартай эх үүсвэр билээ.

Дэлхий дээр хүн төрөлхтөн эрчим хүчний нийт хэрэгцээнийхээ

**10** хувийг цөмийн эрчим хүчээр хангаж байна (Дэлхийн цөмийн нийгэмлэг, 2021 оны 5 дугаар сар)

### I Цацраг идэвхт ашигт малтмалын талаар баримталж буй бодлого

Монгол улсын төр, засгаас цацраг идэвхт ашигт малтмалын нөөцийн хайгуулыг нэмэгдүүлэх бодлого баримталж байна. Ингэснээр ашигт малтмалын нөөцийн хайгуул, ашиглалт, боловсруулалтыг өндөр чанартай хийж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх өндөр технологи нэвтрүүлж, хөгжүүлэх зорилготой билээ.

Монгол улсын Цөмийн энергийн тухай хууль, Монгол улсын төрөөс Цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн эрчим хүчний талаар баримтлах бодлогын дагуу цацраг идэвхт ашигт малтмалын ордыг хэмжээнээс үл хамаарч, стратегийн ач холбогдолтой ордод хамааруулдаг.

Монгол улс цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн эрчим хүчний салбарт хамтран ажиллах тухай харин ойлголцлын санамж бичгийг Америк, Канад, Орос, Өмнөд Солонгос, Чех, Франц, Энэтхэг, Японтой байгуулжээ. Монгол улс цацраг идэвхт ашигт малтмалын салбарын хууль эрх зүйн орчноо олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэхээр чармайн ажиллаж байна.

Монгол Улсын Их хурлаас салбарт баримтлах бодлогыг батлав. Үүнд:

- Цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн эрчим хүчний талаар баримтлах бодлогыг 2009 оны 6 дугаар сарын 25-нд,
- 2014–2025 он хүртэл Ашигт малтмал, түүний нөөцийн талаар баримтлах бодлогыг 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр тус тус баталжээ

Өнөөдөр Монгол улс ураны бүртгэгдсэн нөөцөөрөө дэлхийд 12-т бичигдэж байна.

## Зөөвч-Овоо Үйлдвэрлэлийн туршилт


Компани Монгол улсын холбогдох байгууллагуудаас зохих зөвшөөрлийг авснаар үйлдвэрлэлийн туршилтаа 2021 оны 7 дугаар сард эхлүүлээ.

Уул уурхайн төслийн хөгжүүлэлтийн шатанд тухайн төслийн техник, эдийн засаг хийгээд байгаль орчны үндэслэлийг тодорхойлдог. Тухайлбал, геологчдын илрүүлсэн нөөцийг баталгаажуулж, орд болон хүдрийн шинж чанарыг нарийвчлан тогтооно.

Төслийн хөгжүүлэлтийн шатанд үйлдвэрлэлийн туршилт явуулж ордын олборлолтод дээд зэргээр тохирох олборлолт, боловсруулалтын аргыг сонгодог.

Монгол Улсын холбогдох хуулийн дагуу хайгуулын ажлаар илрүүлсэн геологийн нөөцийг бүртгүүлэхэд талбайд туршилт явуулах үүрэг хүлээдэг.

- Үйлдвэрлэлийн туршилтын үр дүнгээр нарийвчилсан ТЭЗҮ-д шаардлагатай өгөгдөл мэдээллээр хангахаас гадна техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг баталгаажуулна.
- Үйлдвэрлэлийн туршилт нь олборлолтод ашиглахаар сонгоод буй газар доор уусган олборлох арга нь байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл бага болохыг батлах өгөгдөл, мэдээллээр мөн хангах юм.
- Үйлдвэрлэлийн туршилтын өөр нэг зорилго нь туршилтын хяналтанд нутгийн иргэдийг оролцуулах билээ. Ингэснээр төслийг нийгэм, байгаль орчны талаас эергээр хүлээн авахад дэмжлэг үзүүлнэ.



## I Зөвч-Овоо орд

Орано групп хайгуулын салбар Кожеговь ХХК-иар дамжуулан Монгол улсад ураны хайгуулын ажлыг 1997 онд эхлүүлсэн бол Зөвч-Овоо тусгай зөвшөөрөлтэй талбайд 2003 оноос хайгуулын өрөмдлөгийн ажлыг эхлүүлж улмаар 2009 онд Зөвч-Овоо ордыг нээн илрүүлсэн.

Нарийвчилсан хайгуулын ажлыг гүйцэтгэн 2013 онд Зөвч-Овоо ордын 54,640 тн геологийн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан. 2018 он хүртэл хийж гүйцэтгэсэн нэмэлт нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнгээр ордын геологийн нөөцийг 93,291 тн болгон нэмэгдүүлж 2020 онд ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан билээ.

Орано группийн салбар Кожеговь ХХК-ийн нээн илрүүлсэн ураны хоёр орд болох Дулаан-Уул, Зөвч-Овоо ордын геологийн нөөц нь Монгол улсын батлагдсан ураны геологийн нийт нөөцийн 50 гаруй хувийг эзэлж байна. Дээрх хоёр ордыг нээн илрүүлсэн нь Монгол Улсын батлагдсан ураны нөөцийг хоёр дахин нэмэгдүүлээд зогсохгүй ураны батлагдсан нөөцөөрөө дэлхийд 12-р байрт орж байна.

Зөвч-Овоо ураны орд нь Сайншандын хүдрийн дүүрэгт, цэрдийн настай сэвсгэр хурдсаар дүүргэгдсэн Зүүнбаянгийн дэд хотгорт байрлах ба тунамал гарал үүсэлтэй ролл фронт төрлийн орд юм.



Бадрах Энержи ХХК-ийн Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтын боловсруулах үйлдвэр, цооногийн талбай, Дорноговь аймгийн Улаанбадрах сум



## I Үйлдвэрлэлийн туршилтад ашиглах технологи

Ордын олборлолтод газар доор уусган олборлох аргыг ашиглахаар сонгоод байна.

In situ” хэмээх латин үг нь “байран дээр нь” буюу “байгаль дээрх анхны байдалд нь” гэсэн утгатай билээ. Олборлолт хийхдээ метал агуулагч чулуулгийг уурхайлан ухалгүйгээр доторх металыг нь олборлодог тул уг аргыг ийнхүү нэрлэжээ.

ГДУО аргаар олборлолт явуулахад уусгагч шингэнийг хүдрийн биет рүү цооногор шахдаг. Хүчилжүүлсэн ус нь хамгийн түгээмэл ашиглагддаг уусгагч шингэн юм. Уг уусмал хүдрийн биетээр нэвтрэхдээ ураныг өөртөө уусгаад, цаашлаад соруулах цооногт хүрч газрын

гадаргуу руу сорогдон гарч ирснээр боловсруулах хэсэгт хүргэгддэг. Ураныг шингэнээс нь салган, худалдаалах боломжтой ураны хүдрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

ГДУО аргыг элсэн чулуун давхаргад орших ураны орд дээр ашигладаг. Уран агуулж буй тус давхарга нь байгалиасаа үл нэвчих чулуулаг бүхий шавран үеэр дээд, доод хэсэгтээ бусад давхаргаас тусгаарлагдсан байх ёстой

Дулаан-Уул, Зөвч-Овоо ордын геологийн нөөц нь **Монгол улсын батлагдсан ураны нөөцийг хоёр дахин нэмэгдүүлээ**

Дэлхий дахинаа олборлож байгаа нийт ураны **57** хувийг ГДУО аргаар олборлож байна.



- Эрдэсжилт агуулагч гүний усны давхарга нь хөрсний усны давхаргаас олон тооны шавран үеэр маш сайн тусгаарлагдсан.
- Эрдэсжилт агуулагч тухайн гүний усны давхаргын ус нь ундны усны стандарт хангадаггүй. Гүний ус нь байгалаасаа натри, хлор, уран болон өөр бусад элементийн өндөр агуулгатай. Өөрөөр хэлбэл, химийн найрлагынхаа хувьд Монгол улсын болон олон улсын ундны усны стандартын шаардлага хангахгүй шинж чанартай байна.

### Гүний усыг хамгаалах зарчим

ГДУО аргыг ашиглахад хүрээлэн буй орчин, байгаль хамгааллын хувьд тулгардаг гол асуудал бол гүний усыг хамгаалах явдал юм. Тиймээс тухайн газрын гүний усыг дараах байдлаар хамгаалдаг. Үүнд:

- ГДУО аргаар олборлолт явуулахын өмнө тухайн бүс нутгийн гүний усны тогтоцыг нарийвчлан судалсан байна,
- ГДУО аргаар олборлолт явуулахад ундны усны нөөцийг эрсдэлд оруулахгүй,
- Олборлолтын бүхий л шатанд олборлолтын бүсээс цөөн километр бүхий тооцоолсон хэсгээс гадагш эрдэсжилт бүхий гүний усны давхаргаас бусад давхаргын гүний усыг эрсдэлд оруулж болохгүй,
- ГДУО аргаар олборлолт явуулахад тухайн олборлолтын бүс дэх бусад усны давхаргад нөлөөлөл үзүүлэхгүй,
- Олборлолтын хугацаанд гүнийн усны урсгал, чанарыг хянах зорилгоор олборлолтын бүсийн дотор, гадна хяналтын цооногуудыг байрлуулдаг,
- Нөхөн сэргээлт хийгдэж, уурхай хаагдсаны дараах гүнийн усны чанар олборлолт эхлэхийн өмнөх усны ашиглалтын ангилалдаа ирнэ.

## ГДУО аргын давуу талууд

ГДУО арга нь ил болон гүний уурхайн уламжлалт аргуудтай харьцуулахад эдийн засгийн үр ашигтай, технологи, байгаль орчны хувьд олон давуу талтай тул сүүлийн жилүүдэд улам өргөн ашиглагдах болсон билээ. Үүнд:


- Үйлдвэрлэлийн хүчин чадлын уян хатан байдал
- Хүдрийн хаягдал үүсэхгүй
- Ил нүх, хаягдлын овоолго үүсэхгүй
- Олборлолт хийхэд ус шавхах шаардлагагүй
- Байгалийн унаган төрхийг хамгийн бага хөндөнө
- Дуу чимээ, тоос ялгарал хамгийн бага хэмжээнд байна.

### Төсөлд ГДУО аргыг ашиглахаар сонгосон шалтгаан:

Зөөвч–Овоо ураны орд нь хөрсний усны түвшингээс доош 150–200 метрийн гүнд, нэвчимтгий, сэвсгэр буюу нягтрал багатай элсэнд оршдог. Ийм нөхцөлд уламжлалт ил болон гүний уурхайн аргаар олборлох боломжгүй.

- Түүнээс гадна Зөөвч–Овоо ордын ураны агууламж бага байгаа нь ( нэг тонн чулуулагт 220 гр уран) техник технологи, эдийн засгийн талаасаа ч ганц боломжтой технологи нь ГДУО арга юм.
- Зөөвч–Овоо ордыг хамрах бүсийн гүний усны нөхцлийг 2006 оноос 200 хяналтын цооногийн тусламжтай судалснаар дараах үзүүлэлтийг баталгаажуулсан. Үүнд:

### Гүний усыг хамгаалах зарчим



# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БИДНИЙ АРГА БАРИЛ

Ураны салбар нь Монгол улсын хувьд шинэ тутам хөгжиж байгаа стратегийн ач холбогдолтой салбар. Бадрах Энержи компанийн хувьд төслөө зөвөөр ойлгуулж, эерэгээр хүлээн зөвшөөрүүлэхэд оролцогч талуудтай тогтмол харилцан яриа өрнүүлэх явдал чухал юм.

## Бадрах Энержи компанийн төслийн үндсэн оролцогч талууд

Төслийн оролцогч тал гэдэг нь компанийн үйл ажиллагааны нөлөөнд их бага хэмжээгээр өртөж, үйл ажиллагаанд шууд болон шууд бус оролцоо хамааралтай иргэн болон бүлгийг хэлнэ.

Бадрах Энержи компанийн үндсэн оролцогч талууд нь Монгол улсын төр, засгийн байгууллага, орон нутгийн иргэд, захиргааны байгууллагууд, судалгаа, шинжилгээний хүрээлэнгүүд юм. Компаниас оролцогч талуудтай дараах байдлаар яриа хэлэлцээг хөгжүүлж ирлээ.

	Хамтын ажиллагааны хэлбэр
Төр, засгийн төв байгууллагууд	Уулзалт, семинар
Орон нутгийн төр, засгийн байгууллагууд	Хамтын ажиллагааны зөвлөл Харилцааны хорооны хурал
Нутгийн иргэд ба малчид	Хамтын ажиллагааны зөвлөл Өрхийн уулзалт Хоёр жил тутмын иргэдийн санал асуулга Семинар Орон нутаг дахь арга хэмжээ
Монгол улсын шинжлэх ухааны салбар	ГДУО, уран ба цөмийн технологийн талаарх эрдэм шинжилгээний семинар
Олон нийт	Олон нийтэд зориулсан компанийн сонин, Нийтлэл, ярилцлага Телевизийн нэвтрүүлэг Семинар Вэб хуудас Фэйсбүүк хуудас
Иргэний нийгэм ба салбарын байгууллагууд	Уулзалт, хурал семинар



## Оролцогч талуудын хүлээлтийг таньж мэдэх

Бадрах Энержи ХХК нь хариуцлагатай уул уурхайн компанийн хувьд үйл ажиллагаа явуулж буй орчноо ойлгох нь зайлшгүй чухал. Компанийн зүгээс төслийн оролцогч талуудтай үр дүнтэй, бүтээлч хамтын ажиллагаа хөгжүүлэхийн тулд яриа хэлэлцээ хийх, хэлэлцүүлэг өрнүүлэх замаар (төр, засгийн байгууллага, орон нутгийн иргэд, ТББ, хэвлэл мэдээлэл, компанийн ажилтнууд) үйл ажиллагаагаа танилцуулж, тэдний хүлээлт, төсөөллийг ойлгон авдаг.

Төслийн оролцогч талуудын хүлээлтийг дараах арга замаар таньж мэддэг. Үүнд:

- Тухайлбал, Монгол улсад болон олон улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд компани нь байгаль

орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг олон нийтэд танилцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, мөн техник, эдийн засгийн үндэслэлийн нэмэлт тодотголыг орон нутгийн захиргааны байгууллагад танилцуулсан билээ.

- Уул уурхайн гэрээ болон гэрээний тусгайлан заалтууд. Бадрах Энержи компани нь Орд ашиглах гэрээг Ашигт малтмал, газрын тосны газартай 2016 онд байгуулсан. Уг гэрээнд Зөвч-Овоо талбайд үйлдвэрлэлийн туршилт хийх тухай заасан билээ. 2018 онд компани Дорноговь аймгийн Улаанбадрах сум, Сайншанд сумын Зүүнбаян багийн засаг дарга нартай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.
- Салбарын мэргэжлийн байгууллага, холбоодтой тогтоосон хамтын ажиллагааны жишээ, цар хүрээ. Монгол улсад ил тод харилцааг дэмжиж, бизнесийн эрүүл орчин хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулахын тулд Бадрах Энержи компани нь ОУИТБС, Монголын уул уурхайн үндэсний ассоциаци, АмЧам буюу Америк-Монголын худалдааны танхим, Монголын бизнесийн зөвлөл болон Монгол-Францын худалдаа, аж үйлдвэрийн танхимд сайн дураар нэгдэн ажиллаж байна. Эдгээр байгууллага нь Монгол улсад хөрөнгө оруулалтыг дэмжих, нэмэгдүүлэх, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах зорилготой ажиллаж байна.
- Оролцогч талуудын судалгааг тогтмол хийж, ажлын төлөвлөгөө боловсруулан ажилладаг. 2012 онд Зөвч-Овоо төслийн оролцогч талуудын судалгааг хийж байсан бол хамгийн сүүлд 2017, 2018 онд шинэчлэн гүйцэтгэлээ.
- Орон нутаг дахь оролцогч талуудтай харилцан яриа өрнүүлэх бүтэц. Бадрах Энержи компани нь 2013 онд Хамтын ажиллагааны зөвлөлийг байгуулсан юм.

Компани нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг олон нийт, нутгийн захиргаанд танилцуулах ажлыг 2020 оны 9 дүгээр сард зохион байгуулж, үүнд **60 гаруй айл өрхийг хамруулсан.**

## Түнш байгууллагууд

ДАРААХ БАЙГУУЛЛАГАД САЙН ДУРААР  
 НЭГДЭН АЖИЛЛАЖ БАЙНА



ДАРААХ БАЙГУУЛЛАГЫГ ДЭМЖИН  
 АЖИЛЛАЖ БАЙНА



Бадрах Энержи ХХК "Дискавер Монголиа 2020" чуулга уулзалтад оролцов

## УУЛ УУРХАЙ, МЕТАЛЫН ОЛОН УЛСЫН ЗӨВЛӨЛ (УУОУМЗ)

ДЭЛГЭРҮҮЛЭХ НЬ

УУОУМЗ нь аюулгүй, шударга, тогтвортой уул уурхай, металын салбарыг хөгжүүлэхэд чиглэсэн олон улсын байгууллага юм. Уул уурхай, металын 28 гишүүн компани болон үндэсний болон бүс нутаг, түүхий эдийн холбоодын 35 гишүүнийг нэгтгэсэн УУОУМЗ нь байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааг бэхжүүлж, уул уурхайгаас нийгэмд хувь нэмэр оруулах өөрчлөлтийн гол хүч нь болдог.

2002 оноос хойш гишүүн нь байгаагийн хувьд Орано групп байгаль орчин, нийгэм, засаглалын цогц шаардлагууд, гүйцэтгэлийн хүлээлтийн талбайн түвшний баталгаажсан байдал болон жил бүр гаргадаг компанийн тогтвортой байдлын тайлангийн найдвартай баталгаажуулалт зэргийг нэгтгэсэн уул уурхайн зарчмуудыг мөрдөж ирлээ.

Бадрах Энержи компани нь Монголын Бизнесийн Зөвлөлийн гишүүн юм. Монголын Бизнесийн Зөвлөл нь **шударга, тогтвортой, олон улсын түвшинд өрсөлдөхүйц бизнесийн орчныг** бий болгох зорилгоор гишүүн байгууллагуудынхаа хууль ёсны нийтлэг эрх ашгийг дэлгэрүүлэн хамгаалж байна.

"Ураныг газар дор уусган олборлох үеийн цацрагийн хамгаалалт" семинар, 2019 оны 12 дугар сар





# БИДНИЙ АМЛАЛТ, ҮҮРЭГ

1   ОРОН НУТГИЙН АРД ИРГЭД.....	18
2   БАЙГАЛЬ ОРЧИН.....	26
3   ХҮНИЙ НӨӨЦ.....	34
4   ЭРҮҮЛ МЭНД, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЦАЦРАГИЙН ХАМГААЛАЛТ.....	40
5   ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭ.....	48

# 1 | ОРОН НУТГИЙН АРД ИРГЭД



Хамтын ажиллагааны зөвлөлийн хурал, Дорноговь аймгийн  
Улаанбадрах сум, 2020 оны 1 дүгээр сар

## Ил тод байдал, зөвлөлдөх яриа хэлэлцээ

Бадрах Энержи компани бизнесийн үйл ажиллагаагаа эерэгээр хүлээн зөвшөөрүүлж, удаан хугацаанд явуулахад төслийн оролцогч талуудтай яриа хэлэлцээ өрнүүлж, зөвлөлдөхийн сацуу мэдлэг, мэдээллээ хуваалцах ажлыг зохион байгуулах амлалт, үүрэг хүлээдэг.

Уг албан ёсны яриа хэлэлцээ нь нүүр тулсан уулзалт, иргэдийн хурал, бичгэн захидал харилцаа гээд бидний ажиллаж буй орчинтой уялдсан байдаг. Зөвлөлдөж, ярилцах сэдвүүд маань ч байгаль орчин, эдийн засагтай холбоотой байх нь элбэг. Оролцогч талуудтай хийх уулзалт, ярианы давтамжийг тогтмол байдлаар хийж ирсэн оролцогч талуудын судалгааны үр дүн дээр тулгуурлан шийддэг.



## I Орон нутгийн хамтын ажиллагааны зөвлөл

Орон нутгийн хамтын ажиллагааны зөвлөлийг 2013 онд Улаанбадрах болон Сайншанд сумын Зүүнбаян багт байгуулан ажиллаж байна.

Орон нутгийн төр засгийн байгууллага, иргэдтэй тогтмол уулзалт хийж, ил тод байдлыг ханган нээлттэй харилцаа өрнүүлэх, санал солилцох, тэдэнд компанийн үйл ажиллагаа болон төсөлтэй холбоотой богино, дунд хугацааны төлөвлөгөөний талаар мэдээлэл өгөх зорилгоор Хамтын ажиллагааны зөвлөлийг байгуулсан билээ.

2020 оны хувьд хамтын ажиллагааны зөвлөлийн анхны хурлыг Улаанбадрах сум болон Зүүнбаян багийн төлөөлөлтэй 1 дүгээр сард хийсэн бол дараагийн хурлыг 7 дугаар сард цар тахлын нөхцөл байдлын улмаас оролцогчдын тоог хязгаартайгаар тогтоож зохион байгууллаа.

Зөвлөлийн хурлаар:

- Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл
- Нийгмийн хариуцлагын төсөл хөтөлбөрийн хэрэгжилт
- Хамтын ажиллагааны гэрээний сунгалт
- Малжуулах төслийн үр ашгийг нэмэгдүүлэх, төсөлд хамрагдах шалгуурт өөрчлөлт оруулах, мал хүлээлцэх гэрээ хийх хугацаа

- Худаг засварын тайлан зэрэг сэдвээр харилцан мэдээлэл солилцож, байр сууриа илэрхийлжээ.

2013 оноос Хамтын ажиллагааны зөвлөлийн хурлыг **Улаанбадрах суманд 24 удаа, Зүүнбаян багт мөн 24 удаа** тус тус зохион байгуулаад байна.

### КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАХ МЭДЭЭЛЛИЙН ӨДӨРЛӨГ

Төслийн оролцогч талуудад компанийн үйл ажиллагааг танилцуулах зорилгоор 2013 оноос мэдээллийн өдөрлөгийг зохион байгуулж эхэлсэн.

Энэ хугацаанд төр захиргааны байгууллага, хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүд, малчид иргэдэд танилцуулга хийсээр ирлээ.

Өдөрлөгөөр компанийн болон нийгмийн хариуцлагын чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийг танилцуулж, зочдын сонирхсон асуултад хариулж, харилцан яриа өрнүүлдэг юм. Зочид туршилтын үйлдвэрийн талбай, төслийн барилга байгууламж, лабораторитай танилцаж, компанийн мэргэжилтнүүдээс дэлгэрэнгүй мэдээлэл авдаг билээ.

2020 онд туршилтын үйлдвэртэй нийт 68 хүн ирж танилцсан байна. Үүнд:

- Ф-Экс-Би (FXB) төсөлд хамрагдсан иргэдийн төлөөлөл 23 хүн (хуудас 22 үзэх)
- Зүүнбаян багийн ахмадын төлөөлөл 20 ахмад настан
- Империл Секьюрити компанийн 13 ажилтан
- Уул уурхайн томоохон компаниудын төлөөлөл нийт 12 мэргэжилтэн багтаж байна.



Малчдын нэгдсэн өдөрлөг, Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Соёлын төв, 2020 оны 1 дүгээр сар

### МАЛЧДЫН НЭГДСЭН ӨДӨРЛӨГ

2020 оны 1 дүгээр сарын 20- ний өдөр Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Соёлын төвд зохион байгуулагдсан Малчдын нэгдсэн өдөрлөгт Бадрах Энержи компанийн ажилтнууд компанийн үйл ажиллагааг танилцуулсан.

Өдөрлөгөөр Монголын малэмнэлгүүдийн нэгдсэн дундын хоршооноос шинэчлэн батлагдсан «Малын эрүүл мэндийн болон генетик нөөцийн тухай хууль»-д тусгагдсан малчдын эрх үүрэг, хариуцлагын талаар танилцуулга хийж, малчдын сонирхсон асуултад хариулт өгсөн.




Зүүнбаян багийн ахмадууд Зөвөч-Овоо туршилтын үйлдвэртэй танилцаж байна, 2020 оны 2 дугаар сар

## Орон нутаг дахь хөрөнгө оруулалт

Бадрах Энержи ХХК нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж эхэлсэн цагаас орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулсаар ирсэн.

Компанийн дийлэнх хувьцаа эзэмшигч Франц улсын төрийн өмчит Орано групп нь 2013 онд Олон улсын уул уурхай, металын зөвлөлийн гишүүн болсон. Ингэснээр уул уурхайн төслүүдээ тухайн орон нутгийн соёл, ёс заншил, онцлогт уялдуулж хэрэгжүүлснээр тогтвортой хөгжлийг бий болгох үүрэг хүлээсэн юм.

2006–2020 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын мөнгөн дүн / Монгол улсын хэмжээнд нийт 6,5 тэрбум төг /



Бадрах Энержи компани Дорноговь аймгийн Улаанбадрах болон Сайншанд сумын Зүүнбаян багийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирэв. Ингэхдээ тухайн орон нутгийн онцлог, хэрэгцээ шаардлагад тохирсон, олон ашиг хүртэгч бүхий эрүүл мэнд, байгаль орчин, усан хангамж, боловсролыг дэмжих төслүүдийг орон нутгийн оролцогч талуудтай харилцан зөвшилцөж хамтран хэрэгжүүлж ирлээ.

2006 оноос хойш ажиллаж байгаа бүс нутгийн **нийгэм, эдийн засгийн хөгжилд 6,5 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт** хийсэн байна.


### Хамтын ажиллагааны гэрээ

Үйлдвэрлэлийн туршилтын хугацаанд Бадрах Энержи компани, нутгийн захиргаа болон ард иргэдийн дундах яриа, хэлэлцээний албан ёсны зарчмыг анх 2018 онд байгуулж байсан Хамтын ажиллагааны гэрээгээр тогтсон билээ.

Хамтын ажиллагааг усны хүртээмж, хүн, малын эрүүл мэнд, боловсрол, соёл, эрчим хүчний хүртээмж болон эдийн засгийн хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлэхээр тохирсон.

2018–2020 онд Бадрах Энержи компани нийт 943,5 сая төгрөгийн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэн хэрэгжүүлж, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлжээ.

2018–2020 онд хийсэн хөрөнгө оруулалтын мөнгөн дүн, сая төгрөгөөр (төрөл, оноор харуулав)



2020 оны хувьд хамтын ажиллагааны гэрээний хэрэгжүүлэх хороо төсөл хөтөлбөрүүдийг тогтсон шалгуурын дагуу сонгож, нийт \*90 гаруй сая төгрөгийг оюутны тэтгэлэгт хөтөлбөр болон сумын эрүүл мэндийн төвд шаардлагатай эмнэлгийн багаж, хэрэгсэл нийлүүлэх зэрэгт зарцуулсан байна.

2020 оны 7 дугаар сарын эцсээр Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжүүлэх хороо хуралдаж, гэрээг дахин нэг жилээр сунгахаар шийдвэрлэв.

*\*Дэлхий нийтийг хамарсан цар тахал дэгдэж, хөл хорионы улмаас зарим үйл ажиллагаа доголдсон ч компани гэрээний үүргээ хүлээж зарим нэг төслүүдийг, тухайлбал боловсролын чиглэлийн оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн.*

## ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ЖИШЭЭ

### ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Бадрах Энержи компани үйл ажиллагаа явуулж байгаа орон нутагтаа мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, боловсролыг дэмжих зорилгоор уг хөтөлбөрийг 2010 оноос тасралтгүй хэрэгжүүлж байна.

2020–2021 оны хичээлийн жилд тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах сурагчдын тоог нэмэгдүүлсэн бөгөөд Дорноговь аймгийн Улаанбадрах сумаас 2, Сайншанд сумын Зүүнбаян багаас 6 сурагч тус тус нэмэгдэж нийт 21 оюутан Монгол улсын тэргүүлэх их, дээд сургуульд амжилттай суралцаж байна.

Бадрах Энержи компанийн оюутны тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш **нийт давхардсан тоогоор 140 удаагийн тэтгэлэг олгож, 290 орчим гаруй сая төгрөгийн санхүүжилт хийгээд байна.**



### ӨНДӨР НАСТАНД ЦАГААН САРЫН ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ

Бадрах Энержи ХХК 2014 оноос сум, багийн өндөр настнуудад жил бүрийн сар шинийн өмнө хүндэтгэл үзүүлж заншсан. Уг арга хэмжээ нь өндөр настнуудын талархлыг хүлээгээд зогсохгүй компанийн залуу үеийнхэнд ахмадаа хүндэтгэх, настнаа тэтгэх уламжлалыг таниулсан арга хэмжээ болдог билээ.

Энэ хугацаанд компани Улаанбадрах сумаас 115, Зүүнбаян багаас 88, нийт 203 өндөр настанд хүндэтгэл үзүүлсэн.

### МАЛЖУУЛАХ ТӨСӨЛ

2006–2007 оны зуднаар мал нь ихээр хорогдсон малчин өрхүүдэд туслах, нөгөө талаас малчин болох хүсэлтэй, цөөн тооны малтай, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой

малчдыг дэмжих зорилгоор манай компани энэ төслийг эхлүүлж байсан.

Малжуулах төсөлд сонгох шалгуурыг малчдын хамт тодорхойлсон. Төслийн малыг нутгийн малчдаас зах зээлийн үнээр худалдан аваад төсөлд хамрагдаж байгаа айх өрхөд дараах зарчмаар шилжүүлдэг. Тухайлбал, сонгогдсон малчин өрхөд 25 эм хонь, 25 эм ямаа нийт 50 бог мал олгодог бөгөөд малчин өрх 3 жилийн хугацаанд малынхаа ашиг шим, төлийг аваад 3 жилийн дараа дараагийн сонгогдсон айлд анх авсан тооны үржилд орох насны залуу эх малыг шилжүүлдэг зарчимтай юм.

Малчин болох хүсэлтэй айлын тоо нэмэгдэж, төсөлд хамрагдах хүсэлт олноор ирэх болсныг харгалзан Бадрах Энержи компани 2019 онд төслөө өргөжүүлэх шийдвэр гаргасан. Ийнхүү Сайншанд сумын Зүүнбаян багийн 5 малчин өрхөөс зах зээлийн үнээр мал худалдан авч, нэмж 5 айлыг малжуулсан билээ. Өнөөдрийн байдлаар малчдын талархлыг хүлээсэн малжуулах төсөлд Улаанбадрах сумын 84 малчин өрх, Зүүнбаян багийн 31 малчин өрх нийт 115 өрх хамрагдан амжилттай хэрэгжиж байна.

## Ж. Эрдэнэтуяа

FXB Mongolia Dornogobi төслийн менежер



### “Хөтөлбөрт хамрагдсан өрхийн орлого нэмэгдэж, хуримтлал өсч байна”

*FXB гэсэн содон нэртэй хөтөлбөрийг Монгол улсад тэр дундаа Дорноговь аймагт анх удаа Орано группийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа юм байна. Хөтөлбөрийн талаар товчхон танилцуулахгүй юу?*

FXB хөтөлбөрийг 2016 оноос эхлэн Дорноговь аймагт хэрэгжүүлж ирсэн. Энэ хөтөлбөр дэлхийн 40 гаруй оронд амжилттай хэрэгжиж байгаа. FXB гэдэг нь Франсуа Ксавие Банү хэмээх хүсэл тэмүүлэлтэй, аврах үйл ажиллагаанд мэргэшсэн нисдэг тэрэгний нисгэгчийн нэрний товчлол

юм. Тэрбээр Малид нисдэг тэргээр даалгавар биелүүлж яваад 24 насандаа амиа алдсан. 1989 онд түүний ээж болон гэр бүл, найз нөхөд нь аврах ажил, өгөөмөр зан, энэрэнгүй сэтгэлийнх нь ач гавьяаг мөнхжүүлж, дэлхийн олон мянган хүүхдийг хамгаалах, эмзэг бүлгийн хүмүүст туслах мөн ядууралтай тэмцэх зорилгоор FXB холбоог үүсгэн байгуулсан.

Энэхүү олон улсын төрийн бус байгууллага нь хүний эрх, эрүүл мэндтэй салшгүй холбоотой зарчмыг суурь болгон

анх үүсгэн байгуулагдсан ба хүний дархлалын олдмол хомсдол болон ядууралд нэрвэгдэж буй дэлхийн олон мянган хүүхдийг хамгаалах үйлсийг сүүлийн хорь гаруй жил хэрэгжүүлж байна.

FXB орон нутгийн хөтөлбөр нь эрүүл мэнд, боловсрол, нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг болон орлогын эх үүсвэрийг бий болгох дэмжлэгийг орлого бага гэр бүлд үзүүлдэг. Мөн улс орон бүрийн нийгэм, соёл, эдийн засгийн хэм хэмжээнд тохируулсан хөтөлбөр бөгөөд орон нутгийн ажилтнууд тухайн газар нутагт түүнийг хэрэгжүүлдгээрээ давуу талтай.

#### **Та бүхэн хөтөлбөрт хамрагдах айл өрхийг хэрхэн сонгодог вэ?**

Юуны өмнө өнчин, эмзэг бүлгийн, олон хүүхэдтэй, ядуурлын шугамнаас доогуур амьдарч буй гэр бүлийг дэмждэг. Тэдгээр айл нь тухайн суурин газартаа тогтвортой амьдарч байгааг мөн харгалзана. Түүнчлэн цөөхөн тооны малтай малчин, өрх толгойлсон аав ээжүүд, боловсрол эзэмшээгүй, орлого олох боломж бага байдлыг ч хардаг. Хөтөлбөрт хамрагдах өрхийг сонгоход Бадрах Энержи ХХК-ийн төлөөлөл хамтран ажилласан.

#### **Үйл ажиллагааны чиглэлийг сонирхвол?**

Эрүүл мэнд, боловсрол, нийгэм, сэтгэлзүйн дэмжлэг, орлогын эх үүсвэр бий болгох чиглэлээр манай хөтөлбөр үйл ажиллагаа явуулдаг.

#### **FXB орон нутгийн хөтөлбөр Дорноговь аймагт 2016 оноос хэрэгжиж эхэлсэн гэсэн. Өнгөрсөн хугацаанд хичнээн айл өрхийг хамруулаад байна вэ?**

2016–2018 онд анхны хөтөлбөр маань Орано группийн дэмжлэгтэй хэрэгжиж амжилттай дууссан. Төсөл амжилттай хэрэгжсэн тул Орано групп дахин 3 жилийн төслийг маань санхүүжүүлэх шийдвэр гаргасан. Ингэснээр 2019 оны хоёрдугаар сараас хоёр дахь төсөл хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2021 оны 12 дугаар сард дуусах юм. Өмнөх төслийн адил Бадрах Энержи ХХК-ийн үйл ажиллагаа явагдаж буй орон нутагт үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Анхны төсөлд Дорноговь аймгийн Сайншанд сумын 76 өрх, Улаанбадрах сумын 13, Зүүнбаян тосгоны 11 гээд нийт 100 өрх хамрагдсан. 2019–2021 оны хооронд хоёр дахь төсөлд Сайншанд сумын 64 өрх, Улаанбадрах сумын 15, Зүүнбаян тосгоны 16 нийт 95 өрх хамрагдаж байна.

#### **Сүүлийн жилүүдэд тухайлбал 2019– 2020 онд эдгээр айлуудад дэмжлэг үзүүлэх чиглэлээр хийсэн ажлаасаа товчхон танилцуулахгүй юу?**

Хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагааны чиглэлийн дагуу тогтмол сургалт уулзалт зохион байгуулах, сар бүр

төсөлд хамрагдаж байгаа айл өрхүүдийн гэрээр очиж амьдрал ахуйтай танилцах, өрхийн орлого нэмэгдүүлэхээр эхлүүлсэн ажлын явц, орлого зарлагын хөтөлөлт зэрэгтэй танилцаж, уулздаг. Хөтөлбөрийн гол үйл ажиллагаа болох өрхийн орлогын дэмжлэгийг нийт 95 өрх бүгд авч, өөр өөрсдийн ур чадвар, боломж бололцоон дээр тулгуурлан өрхийн үйлдвэрлэл, өрхийн орлогоо нэмэгдүүлэх ажлыг эхлүүлээд байгаа билээ.

Аймгийн төвийн иргэд маань 2019 онд мэдлэг ур чадвараа нэмэгдүүлэхээр хивс нэхэх сургалтанд хамрагдаад 2020 оноос захиалга авч бүтээлээ урлаж байна. Хивснээс гадна хонины ноос боловсруулан эсгий гутал, углааш, улавч зэргийг хийдэг.

Зүүнбаян тосгоны иргэд хамтдаа гар урлал хийж байгаа. Эхний бүтээлээрээ төрөл бүрийн лаа хийсэн. Улаанбадрах сумынхан маань Насан туршийн боловсролын төвийн багштай хамтран мөн л гар урлалын ажил эхлүүлсэн. Тэд ногоо даршлах, лаа, саван хийх сургалтаар ур чадвараа сайжруулж байна.

#### **Гар урлал гэх мэт жижиг үйлдвэрлэл болон ур чадварыг нь сайжруулах сургалтаар тэднийг тодорхой орлоготой болгож байгаа юм байна. Харин хувь хүнийх нь хөгжил дэвшлийг ямар нэг байдлаар дэмждэг үү?**

Дэмжиж байгаа. Хүн эрүүл байж цаашид ажил хөдөлмөр хийж орлого олох, ахуй амьдралаа дээшлүүлэх боломжтой юм. Иймээс FXB хөтөлбөр нь үр шим хүртэгч нараа Аймгийн эрүүл мэндийн газар болон өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах, дархлааг дэмжих ажлуудыг тогтмол зохион байгуулдаг.

Мөн боловсролыг дэмжиж ур чадварыг сайжруулах зорилгоор 2 хүний сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлсэн. Одоогоор 278 хүнд сургалтын хэрэгслийн дэмжлэг үзүүлсэн гэх мэтээр эрүүл мэнд, боловсролын асуудлыг голлон дэмжиж байна.

Орано группийн дэмжлэгтэй 2 удаагийн тус бүр 3 жилийн хугацаатай хөтөлбөр ийнхүү хэрэгжиж олон айл өрхөд бүхий л талаар дэмжлэг үзүүлж байгаад бид баяртай байна. Орано группийн салбар Бадрах Энержи компанийн хамт олонтой хамтран үр өгөөжтэй олон ажлыг цаашид ч хийнэ гэдэгтээ итгэлтэй байна.

## Ёс зүйн дүрэм

Бадрах Энержи ХХК нь нийгмийн хариуцлагатай уул уурхайн компанийн хувьд шударга, ёс зүйтэй үйл ажиллагааг эрхэмлэдэг. Энэхүү зорилгынхоо хүрээнд бид 2018 онд шинэчлэгдсэн Орано группийн ёс зүйн дүрэм болон авилгын эсрэг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг юм. Эдгээрийг Бадрах Энержи компани бүх ажилтан, хамтран ажилладаг түншүүддээ танилцуулан, мөрдүүлж ажилладаг.

Энэхүү дүрэмд группийн зүгээс оролцогч талуудын өмнө хүлээх үүргийг тодорхойлсон байдаг. Түүнчлэн гадаад болон дотоод оролцогчдоос шаардах ёс зүйн хэм хэмжээ, тухайлбал заавал даган мөрдөх ажил хэргийн зан төлвийн дүрэмд нарийн тусгасан байдаг.


Орано группийн ёс зүйн дүрэмтэй [www.orano.gouv](http://www.orano.gouv) вэб хуудсаар нь дамжуулан танилцах боломжтой.



Ёс зүйн дүрэм гарын авлагыг компанийн **хүний нөөцийн хэлтсээс** бүх ажилтанд тараасан.

2020 онд дараахь арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулав. Үүнд:

- Жил бүр компанийн захирал, менежерүүд хүлээн авсан бэлэг болон төрөл бүрийн урилгаа компанийн удирдлагад мэдэгддэг.
- Гэрээт компанийн мэдээллийн сувгаар дамжуулан манай ажилтнууд ёс зүйгүй үйлдлийн талаар «шүгэлдэх» боломжтой. Мэдээлэл боловсруулах явц нууцлалтай хийгддэгийн зэрэгцээ шүгэл үлээгчийг найдвартай хамгаалах механизмтай.
- Компанийн удирдлагын зүгээс ёс зүйн дүрэм болон шүгээл үлээх тогтолцооны талаар ажилтнууддаа байнга мэдээлэл өгсөн.
- Орано группийн ёс зүйн дүрэмд суурилсан цахим сургалтад ажилтнуудаа хамруулдаг. Шинэ болон бусад бүх ажилтнуудаа хамруулдаг ба өөрөө бие даан цахимаар хамрагдаж, мэдлэгээ шинэчлэх бүрэн боломжтой.



Ёс зүйн дүрэм, ялангуяа биеэ авч явах тухай дүрмээр дараах нөхцөл байдалд ямар арга хэмжээ авахыг тодорхойлдог. Үүнд:

- Олон улсын гэрээг дагаж мөрдөх
- Сонирхлын зөрчил
- Дотоод арилжаа
- Авилга
- Бэлэг сэлт ба зүй бусаар давуу тал олж авах,
- Албан тушаалаа урвуулан ашиглах, гуравдагч талтай харилцаа тогтоож, төлбөр авах
- Өрсөлдөөн

- Өмгөөлөл ба лобби хийх
- Улс төрийн санхүүжилт
- Хүн болон эд хөрөнгийн хамгаалал
- Сайн санааны ажил, хандив, ивээн тэтгэх үйл ажиллагаа зэрэг болно.

Орано группийн ёс зүйн дүрэмд суурилсан цахим сургалтын хөтөлбөрт бүх ажилтан болон шинээр ажилд орж байгаа ажилтнуудаа заавал хамруулдаг. Цахим сургалтыг монгол хэлээр авах боломжтой.

## Ялгаварлан гадуурхах явдал болсон нөхцөлд гомдол гаргах, мэдээлэх систем



Компанийн ажилтан ёс зүйн дүрмийн зөрчлийн тухай биечлэн мэдсэн буюу харсан, эсвэл ёс зүйн томоохон зөрчлийн хохирогч болсон бол дараах алхмыг хийнэ. Үүнд:

- Өөрийн шууд удирдлага болох менежертээ эсвэл хууль, дүрмийн нийцлийн ажилтанд мэдээлнэ.
- Эсвэл нууцлалыг сайтар хангадаг Орано группийн шүгэл үлээх вэб сайтаар мэдээллээ илгээнэ.

Хууль, журмаар тогтоосон үүргээ зөрчсөн, эсвэл ёс зүйн дүрэм, хууль, дүрмийн нийцлийн бодлого, түүнийг дагалдах журмыг зөрчсөн аливаа үйлдлийг яаралтай мэдэгдэх нь ажилтны үүрэг бөгөөд үүнийг зуршил болгох ёстой.

<https://OranoEthic.signalement.net>



## Өргөдөл гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам

2020 сүүлээр шинэчилсэн байдлаар хэрэгжиж эхэлсэн Бадрах Энержи ХХК-ийн өргөдөл гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам нь аливаа асуудлыг шүүхийн маргаан болохоос өмнө урьдчилан шийдвэрлэх зорилготой юм. Компани санал хүсэлтээ илэрхийлсэн гуравдагч этгээдийн тодорхой баримт бүхий өргөдөл гомдлыг хүлээн авч, шаардлагатай хариултыг цаг хугацаанд нь өгч, шийдэл олохын тулд бүх хүчин чармайлтаа дайчлан ажиллаж байна.

Өргөдөл, гомдол гаргагч нь тодорхой баримттай өргөдөл, гомдлоо компанид гаргахад түүнийг бүртгэн авсны дараа шинэчилсэн журамд заасан хоёр сарын хугацаанд компанийн холбогдох хэлтэс, ажилтнуудын оролцоотой шийдвэрлэнэ. Өргөдөл гомдол, тэдгээрийг шийдвэрлэсэн талаарх тайланг жил тутам хамтын ажиллагааны зөвлөлд танилцуулж ажиллана.

**Санал, Гомдол...**

**Хэрхэн, яаж санал гомдлоо гаргах вэ?**

Хүн санал, гомдол гаргах эрхтэй эв? Хувь хүч эсвэл бүтэц хүчүүс

Ямар төрлийн санал, гомдол гаргах боломжтой эв?

Мэргээн, чадвартай асуудлаар тайлбар хүссэн, компанийн үйл ажиллагаа, түүхэн-иргэдэд хүргэх (бодит эхэлт тэмдэглэл бүт) нөхөнхийн /галарх санал, гомдол.

Таны гомдол бодит баримт дээр суурилсан байх шаардлагатай.

Хурлын нээлтээс хойш асуудлаар санал, гомдол хүлээн авах боломжгүй.

Таны санал гомдлыг шийдвэрлэх нь: Үүнд хоёр хувилбар байна:

- Өсгөн хөрөнгө хангалттай гэж үзэхэд санал, гомдлын хавтгаг материалыг хаана.
- Өсгөн хөрөнгө хангалтгүй гэж үзсэн тохиолдолд санал, гомдлоо дахин илгээх хэрэгтэй. Компанийн ажилтнууд таны санал, гомдлыг дахин судана.

Тантай хамтран ажиллах хэлтэс:

Компанийн Тогтвортой хөгжил, орон нутгийн харилцаа хэлтэс

У хэлтэс нь компанийн бусад хэлтэстэй хамтран таны санал, гомдлыг хамгийн оновчтой шийдвэрлэх аргыг өгнө.

Гомдлоо хэвээр гаргах эв? Утас: 94091185 / 99103412 | Цахим гурвалж: ENK | Email: enkhjargal.tserendorj@orano.group

Компанийн санал, гомдолыг авах: Мянгол Уулс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Мянгол Гений гудамж, 9, АЙСИСи цэвэр, 8-р давхар | Мэдээллийг үргэлжлэн авах, хуудас, өгөгдөл, өөр дотоо хуудас бүтээн байгуулсан харилцаа: Тус, мөчлөг

Хэзээ хариуцаа авах эв? "Бадрах Энержи" компанийн таны санал, гомдлын хариуг санал, гомдлыг таны хүлээн авснаас хойш хоёр сарын дотор өгнө.

www.badrakhenergy.com

**Санал, Гомдол...**

**... таныг сонсоход бид бэлэн!**

"Бадрах Энержи" компани иргэдийн санал, гомдлыг илүү ихээр сонсох шийдвэрлэх механизм, механизм, шийдвэрлэх хэрэгжүүлж эхэллээ.

Энэхүү механизм нь ирсэн санал, гомдлоо хариуцж, шийдвэрлэх хугацааг оролцоо талуудад мэдэгдэхээр хэвээр ажиллах шаардлагыг өгж болгоно.

Таны санал, гомдлыг мэдэх нь бидэнд хариуцаа өгөхөд буй харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлж, хөгжүүлж болно.

**Бидний үүрэг:**

- Хүлээн авч, судалгааг эхлүүлэх
- Боломжит хугацаанд хариулах
- Аливаа асуудлыг ил тод судалж үзэх
- Таны хүлээлтэнд нийцсэн шийдлийг эргэлтэйлэх
- Хариуцлагатай байх

"Бадрах Энержи" компани нь оролцоо талуудтай ил тод харилцаа хөгжүүлэхээр арга хэлтээ хийхийг эргэлтэд. Компани олон улсын уул уурхай, олборлолт салбарын шилдэг арга туршлагыг хэрэгжүүлж ажилладаг.

www.badrakhenergy.com

## Төлбөр тооцоон дахь ил тод байдал

Орано групп 2003 онд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагад нэгдэн орсон. Ингэснээр ажиллаж буй улс орны төр, засгийн байгууллагад төлж байгаа ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөө илүү ил тод болгох үүрэг хүлээсэн.

Монгол улс тус санаачилгад 2008 онд нэгдсэн бөгөөд түүнээс хойш Монгол улсад ажиллаж буй Орано группийн салбар компаниуд төлбөр тооцооны мэдээллээ тайлагнаж ирлээ. Иймээс Бадрах Энержи компаниас төр, засгийн

байгууллагуудад төлж буй бүх төлбөрөө санаачлагын тайланд нээлттэй тусгадаг. Тайлантай <http://www.eitmongolia.mn> хуудсаар танилцаж болно.

2017–2020 онд **нийт 6,9 тэрбум төгрөгийг Ашигт малтмал, газрын тосны газарт тусгай зөвшөөрлийн төлбөрт төлсөн**

**Бадрах Энержи / АРЕВА Монгол / Кожеговь компанийн төлсөн татварын дүн (2017-2020), тэрбум төгрөгөөр**

ТӨГРӨГ	2017	2018	2019	2020	2017–2020 онд нийт
Нийт	4,9	6,4	3,4	2,9	17,853

Эх сурвалж: ОУИТЭС тайлан (байгаль орчны барьцаа, торгууль, хандив, ТХОНХ, үйлчилгээний төлбөр, түүхэн зардлын нөхөн төлбөр ороогүй болно).

**Бадрах Энержи компаниас тусгай зөвшөөрлийн төлбөрт төлсөн төлбөр, тэрбум төгрөгөөр**

ТӨГРӨГ	2017	2018	2019	2020
Нийт	2,3	2,5	1	1

ЦУХАЛ МЭДЭЭЛЭЛ

### ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛАА:

- Утас: 94091185 / 99103412
- И-мэйл: enkhjargal.tserendorj@orano.group
- Шуудан: Бадрах Энержи ХХК Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1–р хороо, Жамъян гүний гудамж 9, АйСиСи цамхаг, 8 давхар

Бадрах Энержи ХХК нь нягтлан бодох бүртгэлийн тусгайлан хяналтын тогтолцооны шаардлагуудыг үргэлжлүүлэн мөрдөж ажиллахын зэрэгцээ авилгын эрсдэлийн талаарх нүүр тулсан сургалтыг удирдлагын баг мөн эрсдэлд өртөх магадлал өндөртэй хэлтсийн ажилтнуудад зохион байгуулж байна.

## 2 | БАЙГАЛЬ ОРЧИН



Аливаа уурхай тухайлбал ураны хүдэр олборлож боловсруулах үйл ажиллагаанд түүхий эд материал, байгалийн нөөц, тэр дундаа ус болон эрчим хүч хэрэглэдэг. Бидний зорилго бол байгалийн нөөцийн хэрэглээ мөн хог хаягдлын хэмжээгээ багасгаж, дахин боловсруулж улмаар ажиллаж амьдарч буй экосистемээ хамгаалах явдал юм.

**Байгаль орчин хамгаалал нь бидний ажиллаж буй улс орондоо үйл ажиллагаа эрхлэх болон түүнийгээ эерэгээр хүлээн зөвшөөрүүлэх үндсэн түлхүүр гэдэгт бид итгэдэг.**

Орано группийн ХАБ, Байгаль орчны бодлогыг Орано Майнинг компанийн бүх салбар компаниуд баримтлан ажилладаг. Хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж, олон улсын жишигт нийцүүлэн ажиллахын зэрэгцээ Бадрах Энержи ХХК группийн ХАБ, Байгаль орчны бодлогыг дараах байдлаар хэрэгжүүлж байна. Үүнд:

- Урьдчилан санаачлагатай хандах арга барилаар дамжуулан технологийн болон байгаль орчинд үзүүлэх эрсдэлийг багасгах, хязгаарлах
- Үйл ажиллагаанаас байгаль орчинд үлдэх нөлөөллийг багасгах, хязгаарлах, БО-ноо хамгаалах
- Байгаль орчны хариуцлагын удирдлагыг сайжруулах,
- Байгаль орчны болон үйлдвэрлэлийн эрсдэлийн багуудын хамтын ажиллагааг хангах
- Олборлох мөчлөгийн шат бүрт байгаль орчны стандартыг нэвтрүүлэх
- Байгаль орчны удирдлагын тогтолцоог баримталж, хэрэгжүүлэх (ISO 14001 эсвэл дүйцэх стандарт)



## Байгаль орчин хамгаалал

**Орано группийн байгаль орчны бодлогыг Бадрах Энержи компани тууштай хэрэгжүүлж ирлээ. Тиймдээ ч компани төслийн үйл ажиллагаанаас хүн, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага түвшинд барихыг зорин ажилладаг.**

Байгаль орчин хамгаалалтай холбоотойгоор группийн хэмжээнд гарсан ямар нэг сургамжит явдал, сайн туршлагыг тусгайлан боловсруулсан цахим хуудсаар мэдээлдэг.

Бадрах Энержи компанийн төслийн талбайд ажиллаж буй багууд юуны өмнө хүчин төгөлдөр хууль тогтоомж, олон улсын стандартад нийцүүлэн ажиллаж, сайн туршлагыг ажилдаа нэвтрүүлэхийг зорьдог.

Бадрах Энержи компани жил бүрийн төлөвлөгөөт ажлаа Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 онд шинэчлэн гаргасан А-618 журмаар зохицуулж байна. Энэхүү журмын хүрээнд байгаль орчны ажлын гүйцэтгэлээс гадна аж ахуйн нэгжээс орон нутагтай хамтран хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, хууль, дүрмийн гүйцэтгэл, бусад хууль журмаар хүлээсэн үүргийн биелэлтийг хянадаг.

**Манай компани жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үнэлгээ, дүгнэлтээр дараах байдлаар дүгнүүлж ирлээ.**

Үүнд:

- 2017 он: 87,8 оноо
- 2018 он: 88,8 оноо
- 2019 он: Үйл ажиллагаа явуулаагүй
- 2020 он: 90,1 оноо тус тус авсан байна.



Байгаль орчны менежментийн үйл явцын хүрээнд гурвалсан хяналтын тогтолцоог мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- Жил бүр байгаль орчны хяналт шинжилгээ, менежментийн төлөвлөгөөг боловсруулж, БОАЖЯ-аар хянан батлуулдаг. Харин хэрэгжилтийг орон нутгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар хянасаар ирлээ. Төлөвлөгөөний биелэлтийг компанийн байгаль орчны мэргэжилтнүүд хариуцдаг.
- 2010–2011 онд хийсэн газар доор уусган олборлох технологийн туршилтын хяналт шинжилгээг жил бүр хийсээр байна.
- Орон нутгийн удирдлага, иргэдийн төлөөлөл оролцсон Хамтын оролцоотой байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг 2013 оноос эхлэн тасралтгүй зохион байгуулж байна.

Байгаль орчны үйл ажиллагааг жил бүр менежментийн төлөвлөгөөний дагуу 2 төрлөөр шалгаж, баталгаажуулж дүгнэдэг. Үүнд:

- Талбайн ажлын хэрэгжилт
- Компанийн үйл ажиллагааны хүрээнд хуулиар хүлээсэн хэрэгжүүлэх шаардлагатай ажлууд болон төлөвлөсөн ажлуудыг хэлэлцэж дүгнэх хурал гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.

Манай компани 2017 оноос хойш байгаль орчны судалгаа, шинжилгээний дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

- Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян, Улаанбадрах сумын Дулаан-Уул, Дулаан, Зөөвч-Овоо, Өөшийн говь, Өмнөт, Богд Уул орчмын орчны чанарын төлөв байдлын судалгаа.
- Туруутан (хөхтөн) болон шувууны зүйлийн бүрдэл, тоо толгой, шилжилт хөдөлгөөн, амьдрах орчны судалгааны ажлын тайлан.
- Бадрах Энержи ХХК-ийн хэрэгжүүлж буй ураны төслийн байгаль орчны аудитын тайлан
- Загийн бортоготой тарьц ургуулах мод үржүүлгийн газар байгуулах, ойжуулалт хийх үндэслэл, төлөвлөлт.

Байгаль орчны хяналтыг дараах зорилгоор гүйцэтгэж байна. Үүнд:

- Цацраг идэвхт ашигт малтмалын төслийн явцад байгаль орчны нөлөөллийг нарийвчлан тодорхойлох
- Хээрийн хэмжилт судалгаа хийх
- Дээж цуглуулах
- Шинжилгээний үр дүнд боловсруулалт хийж, зөвлөмж, дүгнэлт гаргах
- Байгаль орчин хамгаалах хамтын хяналтыг хэрэгжүүлэх, ард иргэдийг мэдээллээр хангах
- Байнгын хяналтыг хийж тайлагнах
- Аливаа эрсдэл, бохирдлоос сэргийлэх
- Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд шинээр нэмж тусгах байгаль хамгааллын болон хяналт шинжилгээний хөтөлбөрүүдийг санаачлах зэрэг болно.

Хяналт шинжилгээний ажлын үр дүнгээр Бадрах Энержи компанийн төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлсэн сөрөг нөлөөлөл тогтоогдоогүй.

## Ус

**Ус нь үнэ цэнэтэй байгалийн баялаг бөгөөд бүс нутгийн байгаль, ард иргэдийн аж байдал болон Бадрах Энержи ХХК-ийн үйл ажиллагаанд ч чухал үүрэгтэй.**

Уул уурхайн үйл ажиллагаа нь зөвхөн усны нөөцөд төдийгүй түүний чанарт ч нөлөөлөх боломжтой. Тиймээс усан орчныг хамгаалахын тулд усны асуудалд байнга анхаарал хандуулах шаардлагатай.

## ГҮНИЙ УСНЫ СУДАЛГАА

**Бадрах Энержи компани Галба – Өөш – Долоодын Говийн сав газрын захиргаанаас хэрэгжүүлж байгаа газрын доорх усны судалгаанд хамтран оролцож байна.**

Бадрах Энержи компани Галба – Өөш – Долоодын Говийн сав газрын захиргаатай хамтран газрын доорх усны байгалийн болон техноген горимын судалгаанд зориулж газрын доорх усны түвшний хэмжилт, сорьцолтын ажлыг 2015 онд эхлүүлсэн. 2019 оны 2–р улирлаас Зөөвч– Овоогийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд 4 хяналтын цооногийг сонгож, хөтөлбөрт нэмж оруулсан. Усны химийн найрлагын шинжилгээний төрөл болон хяналтын цооногийн сонголтыг сав газрын захиргааны удирдамжийн дагуу хийсэн. Ажлын үр дүнгийн тайлан мэдээллийг БОАЖЯ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар болон Сав газрын захиргаанд улирал тутам тогтмол хүргүүлэн ажиллаж байна.

ОНЦЛОХ НЬ

### Ашигласан усны хэмжээ

Он	Ашигласан ус, тонн
2018	6,270
2019	3,768
<b>2020</b>	<b>2,709</b>

Бадрах Энержи ХХК нь үйл ажиллагааныхаа үе шат бүрт усны хэрэглээг бууруулахыг эрмэлздэг. Компанийн усны зарцуулалт 2018 онд 6 270 тонн байсан бол 2019 онд 50 гаруй хувиар буурсан. Ийнхүү буурсан нь үндсэндээ Зөөвч–Овоо үйлдвэрлэлийн туршилтын бэлтгэл шатанд компанийн үйл ажиллагааны хэмжээ багассантай холбоотой. Ирэх жилүүдэд ажлын цар хүрээ өргөжихтэй уялдаад усны

хэрэглээ ч өснө. Үйлдвэрлэлийн туршилтаа хэрэгжүүлснээр Бадрах Энержи ХХК үндсэн үйлдвэрлэлийн шатанд усны зарцуулалтаа багасгах шилдэг арга аргачлалыг сонгон хэрэгжүүлэх боломжтой болно.

### Малчдын худгийн усны хяналт

Бид үйл ажиллагааныхаа онцлогоос хамааран малчдын худгийн усны хяналтын ажлыг хэдэн үе шаттайгаар хэрэгжүүлдэг. Тэгэхдээ дотоодын болон хөндлөнгийн байгууллагын хяналтаар давхар баталгаажуулдаг. Компани гүний усны хяналтын ажлыг улирал тутам хийдэг ба үр дүнгийн тайланг төр захиргааны холбогдох байгууллагад хүргүүлдэг.





Цаашид сэргээгдэх эрчим хүчийг илүү ашиглахыг эрмэлзэж, эрчим хүчний хэрэглээгээ оновчтой байдлаар зохион байгуулна. Компанийн зүгээс үндсэн үйлдвэрлэлийн шатанд хэрэгжүүлвэл зохих арга хэмжээг тодорхойлох зохих судалгаануудыг эхлүүлнэ.

## Хог хаягдал

Уул уурхайн үйл ажиллагаанаас хаягдал үүсдэг. Тэгвэл аж ахуйн нэгжүүд уг хог хаягдлыг оновчтой зохицуулж, байгаль орчны холбогдолтой хууль тогтоомжийг биелүүлэн аливаа нөлөөллийг багасгаснаар үйл ажиллагаагаа эерэгээр хүлээн зөвшөөрүүлнэ.

Бадрах Энержи ХХК цацраг идэвхт болон ахуйн хог хаягдалдаа хууль тогтоомжийн дагуу оновчтой зохицуулгыг хийдэг.



Хог хаягдлын зохицуулгыг олборлох төслийн бүхий л үе шатанд чухалчлан авч үздэг. Бадрах Энержи хог хаягдал дахин боловсруулах мэргэжлийн компаниудтай хамтран ажилладаг.

Энэ төрлийн хамтын ажиллагаагаа цаашид ч үргэлжлүүлнэ.

Компани хуванцар хог хаягдал болон ашигласан тосыг 100 хувь дахин боловсруулах зорилго тавин ажиллаж байна. Компанийн хувьд бүх ажилтнуудаа хог хаягдлаа дахин боловсруулах, ангилах ажилд оролцуулах нь чухал байдаг. Манай ажилтнуудын хичээл зүтгэлийн үр дүнд өнгөрсөн жилүүдэд хог хаягдлын хэмжээ үлэмж хэмжээгээр буурсаар байна.

### Хатуу хог хаягдлын тайлан

Он	Килограмм
2018	4,082
2019	3,286
2020	3,421

## Уур амьсгал

Цөмийн эрчим хүч нь нүүрстөрөгч бага ялгаруулдаг цахилгаан эрчим хүч рүү шилжихэд чухал үүрэгтэй гэдэгт итгэдэгийн хувьд Орано групп нь 2004 оноос хүлэмжийн хийн ялгарлаа багасгаж, Парисын Гэрээний зорилтыг биелүүлэхэд хувь нэмрээ оруулахын тулд олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Бадрах Энержи ХХК нь мөн үйл ажиллагааныхаа хэмжээг багасгаж, дизель түлшний хэрэглээгээ 30 гаруй хувиар бууруулжээ. Компани 2018 онд 311 865 литр түлш ашиглаж байсан бол 2020 онд 209 388 литр хүртэл буурууллаа. Тээврийн хэрэгслийн ашиглалтыг оновчтой зохион байгуулах нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чухал үүрэгтэй билээ.

## Эрчим хүч

Үйл ажиллагаагаа тасралтгүй мөн хөдөлмөрийн аюулгүй байдлыг дээд зэргээр ханган явуулахын тулд Бадрах Энержи ХХК баталгаатай эрчим хүчний хангамжтай байх ёстойн зэрэгцээ нүүрстөрөгч ялгаруулалтаа бууруулж, цаашид ч хэрэглээгээ үргэлжлүүлэн багасгах шаардлагатай.

2020	Хатуу хог хаягдал, кг		Дахин боловсруулах хог хаягдал, кг			
	Органик	Ахуйн	Хуванцар	Шил	Лааз	Цаас
	589.7	1,485.8	607.1	246.9	144.3	347.2
Нийт	2, 075.5		1,345.5			

## Л. Эрдэнэсайхан

Хатандалай ХХК-ийн гүйцэтгэх захирал



“ **Бид байгаль орчны хяналт шинжилгээний ажилдаа олон нийтийн оролцоог заавал хангадаг** ”

Бадрах Энержи компани 2018 оноос байгаль орчны хөндлөнгийн хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх чиглэлээр Хатандалай ХХК-тай хамтран ажиллаж байна. Компани 2018 онд энэхүү ажлын гүйцэтгэгчийг сонгосон.

*Байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх нь ямар ач холбогдолтой вэ?*

Мэдээж энэ бол маш чухал асуудал. Тухайлбал, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль хамгаалах тухай хууль болон үүнтэй холбоотой журмын холбогдох заалтуудаар аливаа төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийн эрчим, үргэлжлэх хугацааг жил бүр тогтоох, түүнийг хянаж үнэлэх арга хэмжээг тодорхой тусгасан байдаг. Энэ үйл

ажиллагааг мэргэжлийн, тэр дундаа төсөл хэрэгжүүлэгч компанийн үйл ажиллагаанд огт оролцдоггүй хөндлөнгийн байгууллага хийх нь илүү ач холбогдолтой. Мэдээж хэрэг өөрийнхөө үйл ажиллагааг өөрөө хянаад явах, эсвэл хөндлөнгийн байгууллагаар хяналтаа хийлгэх ялгаатай биз дээ. Тэгэхээр энэ ажлыг гүйцэтгэх явцад бүх тал бие биедээ хуулийн хүрээнд ижил тэгш хяналт тавьж байж ажлын үр дүнг бодитой болгоно.

***Байгаль орчны хөндлөнгийн хяналт шинжилгээг ямар арга аргачлалаар хийдэг вэ? Мөн талуудын хяналт гэдгийг юу гэж ойлгох вэ?***

Байгаль орчны хөндлөнгийн хяналтын гол зорилго нь товчхондоо аливаа төсөл хэрэгжсэнээр байгаль орчинд ямар хэмжээний сөрөг нөлөөлөл учруулж байгаа, тэр нь ямар эрчмээр, хэдий хугацаанд үргэлжилж буйг тодорхойлохоос гадна түүнийг хэрхэн бууруулах талаар зөвлөмж дүгнэлт гаргахад оршино. Энэ ажил хууль эрх зүйн талаасаа ч зохицуулагдсан байдаг. Тухайлбал, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9-р зүйлд байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь юу юунаас бүрдэх вэ гэдгийг тусгасан. Үүнийг дагаж гарсан Байгаль орчны сайдын А168-р тушаал, мөн Байгаль хамгаалах тухай хуулийн 10-р зүйл заалтаар зохицуулсан байдаг.

Манай компанийн хувьд хуулийн хүрээнд холбогдох арга аргачлалын дагуу энэ ажлыг гүйцэтгэж байгаа. 2018 оноос хойш жилд 2 удаа хөрс, ус, агаар, ургамлын дээж авах хатуу цэгүүдээс хөндлөнгийн хяналтан дор дээжлэлт авч стандартын дагуу битүүмжилсэн саванд савлаад итгэмжлэгдсэн лабораториудад шинжлүүлж байна. Ингээд лабораторийн үр дүнд тулгуурлан тайлангаа боловсруулдаг.

Манай компанийн хувьд байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэхдээ олон нийтийн оролцоог заавал хангадаг. Тухайлбал ТББ, нутгийн иргэд, орон нутгийн төр захиргааны байгууллагын төлөөллийг байлцуулж байгаад дээжүүдээ авч лацаддаг. Энэ үйл ажиллагааг Бадрах Энержи компанийн зүгээс ч маш сайн дэмждэг. Өөрсдөө ч хяналтаа сайн тавьдаг. Одоогоор энэ ажлыг гүйцэтгэхэд Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн мэргэжилтэн болон Улаанбадрах сумын байгаль орчны байцаагч, малчдын төлөөллөөс оролцуулж байна.

***Танай компанийн ажлын үр дүнд зөвлөсөн зөвлөмжийн дагуу Бадрах Энержи компани байгаль хамгаалах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн сайн туршлагууд байна уу?***

Бадрах Энержи компанийн үйл ажиллагаанд бид сүүлийн гурван жил хяналт шинжилгээний ажил хийсний үр дүнд

хог хаягдлын менежмент, нөхөн сэргээлт, зэрлэг ан амьтныг хамгаалах гэх мэт тодорхой асуудлаар зөвлөмж өгч байгаа. Үүний үр дүнд Говийн эко системд тэсвэртэй нөхөн сэргээлтийн ажлыг санал болгож байсан юм. Түүний дагуу Бадрах Энержи компани заг тариалах судалгааг мэргэжлийн байгууллагын зөвлөмж, дүгнэлтэд үндэслэн өөрийн байгуулсан хүлэмж, талбай дээрээ туршилтын ажлыг маш амжилттай хэрэгжүүлээд явж байна. Энэ бол сайн туршлага.

***Эцэст нь байгаль орчны хяналт шинжилгээний ажлын үр дүнг улам сайжруулах тал дээр ямар санал санаачилга байна вэ?***

Дээжүүдийг дээж авах цэгүүдээс яг тогтсон хугацаанд норм журам, технологийн дагуу авч лабораторт шинжлүүлэх, гарсан үр дүнг мэргэжлийн шинжээчид зөв тайлбарлах, оновчтой дүгнэлт, зөвлөмж өгөх, нөгөө талд хөндлөнгийн хяналт шинжилгээг хийлгүүлсэн байгууллага тэндээс гарсан зөвлөмжийг үйл ажиллагаандаа маш сайн мөрдөж ажиллах ёстой гэж боддог.

Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тайлан, орчны хяналт шинжилгээний ажлын хөтөлбөр, тухайн жилийн байгаль хамгаалах ажлын төлөвлөгөө зэрэг нь уялдаж байж төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн нь зөв, сайн байна. Үүнийг хийхийн тулд мэдээж төсөв, санхүүгийн асуудлыг төсөл хэрэгжүүлж буй компаниуд хангалттай хэмжээнд шийдэж байх хэрэгтэй. Хяналтын ажлаа сайн хийгээд, төлөвлөгөөгөө зөв боловсруулаад явбал байгаль хамгаалах ажлыг сайн хийх боломжтой.

Энэ явцада тухайн ажлуудаа засаж сайжруулах чиглэлээр мэргэжлийн байгууллагаас зөвлөмж авч хэрэгжүүлдэг, салбарын ТББ- уудтай хамтран ажилладаг байх нь мөн сайн үр дүнг авчрах юм.

ЯРИЛЦЛАГА...

## Нөхөн сэргээлт

Ураны хүдрийг олборлох, боловсруулахад шаардлагатай дэд бүтцийг (эрчим хүчний хангамж, зам, байгууламж) хөгжүүлэх шаардлагатай болдог. Ингэх явцад байгаль орчинд нөлөөлөл үүсэх бөгөөд уг нөлөөллийг үнэлж, багасгаж мөн хянах нь чухал.



Аливаа эрсдэлд бэлтгэлтэй байхын тулд уул уурхайн төсөл нь хайгуул, хөгжүүлэлтийн үе шатнаасаа л нөхөн сэргээлтээ тооцож, төлөвлөх ёстой. Зарим нөхөн сэргээлтийн ажлыг уурхай ажиллах үед зэрэг хийж эхэлдэг бол техникийн нөхөн сэргээлтийн ихэнхи ажлыг олборлолт дууссаны дараа хийдэг.

Уурхайн хаалтын үеийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой нийгмийн нөлөөллийг тооцохдоо аль болох эртнээс холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагаагаа уялдуулан зохицуулж, дотоод, гадаад оролцогч талуудтай зөвлөлдөх замаар төлөвлөдөг.

Нөхөн сэргээлтийн ажлыг оновчтой төлөвлөж, гүйцэтгэх нь нутгийн иргэд, төрийн байгууллагууд болон бүх оролцогч талын итгэлийг хүлээхэд чухал үүрэгтэй. Компанийн үйл ажиллагааг урт хугацаанд эерэгээр хүлээн зөвшөөрүүлж, нутгийн иргэд болон тухайн



ДЭЛГЭРҮҮЛЭХ НЬ

### Төслийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө:

- **Цооногийн талбай:** цооногийг дүүргэж, газрын гадарга дээрх байгууламжийг татан буулгаж, газрыг нөхөн сэргээнэ.
- **Үйлдвэрийн байгууламж:** татан буулгаж, газрыг нөхөн сэргээнэ.
- **Уст үе:** олборлолт явуулсан талбайн уст давхаргад байгалийн аясаар нөхөн сэргээлт үр дүнтэй болохыг батласан судалгаанууд, гидрогеологийн судалгаа зэрэг дээр үндэслэн байгалийн аясаар нөхөн сэргээгдэх явцыг хянана.
- **Дахин ургамалжуулах:** байгаль орчны дүйцүүлэн хамгаалах төслийн хүрээнд нөхөн сэргээсэн талбай болон ойр орчмын газарт заг (дархан цаазат мод) тарина.
- **Уст үеийн хянан ажиглалт:** 88 хяналтын цооногийн сүлжээгээр хянана.

улсын зүгээс “ажиллах зөвшөөрөл” авахад ч мөн чухал билээ.

2020 онд Бадрах Энержи компани хайгуулын үед ашиглаж, дүүргэлт нь зохих хэмжээнд хүрсэн шаврын сангийн нөхөн сэргээлтийн ажлыг амжилттай хийлээ. Шаврын сангийн дүүргэлтийг 60 хувиас хэтрүүлэлгүй, үндэсний MNS 5917:2008 стандартын дагуу нөхөн сэргээлтийг хийж 30–40 см өнгөн хөрсөөр хучиж тэгшилсэн. Нөхөн сэргээлтийн дараа цацрагийн хэмжилтийг хийж баталгаажуулсан







бөгөөд тус нөхөн сэргээгдсэн талбайн байгаль орчны хяналтыг орон нутагт бүрэн буцаалт хийх хүртэл үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

## I Биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг багасгана

Олборлох төслөөс биологийн олон янз байдалд үзүүлэх элэгдлийг зохицуулахын тулд “бууруулах дараалал” буюу “зайлсхийх – бууруулах – нөхөн сэргээх – дүйцүүлэн хамгаалах” дарааллыг төслийн эхний үе шатаас эхлэн хэрэгжүүлж, байгаль орчны нөлөөллийн судалгааны зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана. Бид биологийн олон янз байдлын тэнцвэрийг алдагдуулахгүй байх зорилготой.

Компанийн төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөө хэдийгээр маш бага ч гэсэн талбайн ажлаас ургамал, амьтанд үзүүлэх нөлөөг багасгах арга хэмжээг байнга авч хэрэгжүүлдэг. Үүнд:

- Хээрийн ямар нэг ажлын талбарыг аль болох бага зай талбай эзэлж, том хэмжээний газар талхлагдахаас сэргийлэх байдлаар зохион байгуулах
- Авто хэрэгслээс санамсаргүй тос асгарч, хөрс бохирдуулахаас сэргийлэх
- Төслийн талбайд ургамал, тухайлбал загийг хамгаалж тусгаарлах зэрэг урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг гүйцэтгэж байна.

ОНЦЛОХ НЬ

### Заг үржүүлэн тарих

Салбарын мэргэжлийн байгууллагын нэг болох Монгол Улсын Их Сургуультай хамтран заг үржүүлэн тарих төслөө эхлүүлсэн ба төсөл үргэлжилж байна. Энэ төслийн хүрээнд Зөөвч-Овоо тусгай зөвшөөрөлтэй талбайд үрсэлгээний хүлэмж байгуулаад байна.

## I Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

Дүйцүүлэн хамгаалах төслийн хүрээнд тариалалтын зарчмаа (арга барил, төрөл зүйлийн сонголт зэрэг) илүү оновчтой зохион байгуулахдаа газрын онцлог, хүрээлэн буй экосистем мөн нутгийн иргэдийн аж ахуй, заншил зэргийг харгалзана.

Анхны судалгаагаа Дорноговь аймагт хийж дуусгалаа. Экосистемийн тооллогыг уламжлалт ургамал зүйн судалгаатай зэрэгцүүлэн хийснээр хүн ам болон малын тэжээлийн хэрэгцээнд шаардлагатай, аж ахуй ба эмчилгээнд чухал ургамлын төрөл зүйлсийн хэрэгцээг тодотгож чадав. Уг ажлыг гүйцэтгэснээр дүйцүүлэн хамгаалах зарчмын талаарх ойлголтоо өргөжүүллээ. Компани 2020 онд CIRAD буюу Францын Олон улсын хөгжлийн төлөө газар тариалангийн судалгааны төвтэй хамтран, уг сэдвийг нарийвчлан судлах зорилгоор экосистемд явуулах үйлчилгээний арга барилыг холбогдох газруудад ерөнхийлөн нийцүүлэх зорилгоор докторын зэргийн судалгааны ажлыг эхлүүлээд байна.

Зөөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтын Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд дараах дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тусгасан. Үүнд:

- 2017 онд бэлтгэл ажил эхлэх үед байгаль орчны судалгаа, үнэлгээний “EGIS” компанитай хамтарч, төслийн ерөнхий төлөвлөлтийг боловсруулсан.
- 2018 оны 6 дугаар сард компанийн байгаль орчны ажилтнууд Өмнөговь аймаг дахь дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлдэг аж ахуйн нэгжүүдийн туршлагыг судалсан.
- 2019 онд туршилтын тариалалтын төлөвлөгөөг боловсруулсан.
- 2020 онд хүлээмжийн байгууламжийг дуусгаж, тариалангийн талбайг сонгосон.



# 3 | ХҮНИЙ НӨӨЦ



Ажилтнуудаа ирээдүйд өсч дэвших ур чадварт урьдчилан бэлдэж, улс орон болон салбар хооронд шилжин ажиллах боломжоор хангаж, үндсэн мэргэжлээр нь нарийн мэргэшүүлэхийн хамт хүйсийн тэнцвэрт байдлыг хадгалахад хүний нөөцийн бодлогоо чиглүүлэн хэрэгжүүлж байна. Компанийн зүгээс техникийн болон удирдах ур чадварын төрөл бүрийн сургалтыг тогтмол зохион байгуулдаг.

## Компанийн ажилтнууд

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Бадрах Энержи компани нийт 86 ажилтантайгаас 3 нь гадаад мэргэжилтэн бол байнгын ажлын байранд 52 хүн ажиллаж байна. Харин 31 ажилтан хугацаатай гэрээгээр ажиллаж байна.

Бадрах Энержи компани ажлын байрны хэрэгцээ шаардлагыг үндэслэн ажилтнаа сургалт, хөгжлийн ижил тэгш боломжоор хангах, авьяасыг нь нээснээр тохирох албан тушаалд томилох, ажлын өндөр гүйцэтгэл гаргахад шаардлагатай нөхцлөөр хангаж ажиллах зорилгыг баримталж ажилладаг.



2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх ажилтнуудын мэдээлэл:

Категори	Бадрах Энержи ХХК			
	Байнгын гэрээт ажилтан	Гадаад ажилтан	Хугацаат гэрээт ажилтан	Нийт
2020	52	3	31	86
Эмэгтэй	18	0	3	21
Эрэгтэй	34	3	28	65

## I Олон талт байдал

Олон талт байдал нь гүйцэтгэлийн хүчин зүйл, инновацын эх үүсвэр болохын зэрэгцээ мөн ажилтан солилцоог бэхжүүлэн, ур чадварыг сорьж, эргэцүүллийг хөгжүүлдэг гэдэгт Орано групп итгэдэг.

Бадрах Энержи ХХК нь группийн бодлогыг хэрэгжүүлдэг ба компанийн хүний нөөцийн баг чиг үүргээ хэрэгжүүлэхдээ олон талт байдлын хөхүүлэн дэмждэг. Гарал үүсэл, нас, хүйс, арьс өнгө, бэлгийн чиг хандлага эсвэл айдентити буюу бусдаас ялгарах байдал, хөгжлийн бэрхшээл, улс төр, үйлдвэрчний эвлэл, шашны байгууллагын гишүүнчлэл эсвэл үндэсний цөөнх зэргээс шалтгаалсан аливаа гадуурхлаас зайлсхийн ажилтнуудын ур чадвар, ажлын замналыг хөгжүүлдэг.

Компанийн нийт ажилтны 76 хувь нь эрэгтэй ажилтнууд байдаг бол 24 хувь эмэгтэй ажилтнууд юм.



КОДИР буюу захирлуудын зөвлөл дэх хүйс, насны ангилал

КОДИР буюу захирлуудын зөвлөл дэх хүйс, насны ангилал	Хүйс				Насны ангилал
	Эмэгтэй	Эрэгтэй	30 хүртэлх насны	30–50 насны	50–аас дээш насны
	37.5%	62.5%	11.11%	66.67%	22.22%

## Орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь

Бадрах Энержи компани үйл ажиллагаа явуулж байгаа бус нутагтаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг баримталж ирсэн. 2020 оны байдлаар компанийн монгол ажилтнуудын 33 хувь нь Дорноговь аймгийн Улаанбадрах сум, Сайншанд сумын Зүүнбаян багийн иргэд байна.

2020 онд Бадрах Энержи компани нийт 6 шинэ ажилтан ажилд авсан ба хүний нөөцийн гэрээт компаниуд болон орон нутгийн хөдөлмөрийн хэлтэс, хөдөлмөрийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах замаар сонгон шалгаруулалтыг хийж ирлээ. 2020 онд ажилтны шилжилт хөдөлгөөн 4 хувь байв.

Нийт ажилтнуудын **96** хувь нь Монгол улсын иргэд



## Мэдлэгийн менежмент, ажилтнуудын сургалт, хөгжил

Жил тутам ажилтан ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр өмнөх жилийн ажлаа үнэлүүлж, ирэх жилийн зорилгоо тодорхойлон ажиллахын сацуу, ажлын гүйцэтгэлийн үнэлгээний үеэр сургалт хөгжлийн хэрэгцээ, хүсэлт, зорилгоо илэрхийлдэг.

Компанийн зүгээс ажилтнуудаа мэргэжлийн болоод уян хатан ур чадварын сургалтуудад хамруулахаас гадна зэрэг горилох хөтөлбөр, гадаадад зохион байгуулагдаж буй сургалтуудад хамрагдах боломжоор хангагддаг.

2020 онд ажилтнуудад зориулж:

- итгэмжлэгдсэн их, дээд сургуульд зэргийн хөтөлбөр
- мэргэжлийн болон уян ур чадварын сургалтууд
- гэрчилгээ олгох сургалт
- англи, франц хэлний сургалтуудыг амжилттай зохион байгуулсан.

2020 оны хувьд 12 төрлийн сургалтад нийт 49 ажилтан хамрагдсан байна.

- 12 ажилтан зэргийн хөтөлбөрт хамрагдаж,
- давхардсан тоогоор нийт 288 ажилтан 2840 цагийн хөдөлмөрийн аюулгүй байдал, цацрагийн хамгаалалтын сургалтад хамрагдсан.

## Хамтын гэрээ

Бадрах Энержи ХХК-ийн хүний нөөцийн бодлого нь одоогийн хууль тогтоомжийн хүрээнд талуудын хоорондох харилцан яриа, зөвлөлдөх зарчим дээр үндэслэдэг. Компанийн эрүүл зохистой ажиллах амин чухал нөхцөл нь хариуцлагатай, бүтээлч нийгмийн харилцаа юм.

Дийлэнхи хувьцаа эзэмшигч Орано группийн хариуцлагын зарчмын дагуу Бадрах Энержи ХХК нь хоёр жил тутам бүх ажилтны саналаар сонгогддог ажилтнуудын төлөөлөлтэй хамтын гэрээ байгуулсан.

Монгол улсын хөдөлмөрийн хуулийн дагуу хамтын гэрээг дүүргийн засаг даргын тамгын газарт бүртгүүлсэн. Гэрээний хэрэгжилтийг

Сургалтын төрөл	Менежерийн албан тушаалын ажилтан (цаг)	Менежерийн бус албан тушаалын ажилтан (цаг)
Хуулийн дагуу зайлшгүй хамрагдах сургалт	628	2212
Хэлний сургалт	580	24
Мэргэшүүлэх сургалт	65.5	268
Уян ур чадварын сургалт	94	120
	1367.5	2624



ажилтнуудын төлөөлөлтэй хамтран хянадаг. Ажилтнуудын таван төлөөлөл удирдлагын багтай яриа хэлэлцээ өрнүүлж, ажилтнуудын эрх ашгийг компанийн бодлого, шийдвэрт тусгах талаар тохиролцож ажилладаг.

Хамтын гэрээг 2021 оны 5 дугаар сард шинэчилсэн.

2020 онд компанийн удирдлага, ажилтнуудын төлөөлөл хоёр удаа уулзав.

Хамтын гэрээний хүрээнд зарим дотоод журмын шинэчлэл, цалингийн нэмэгдлийн журам, хээрийн нэмэгдэл, хоолны мөнгийг нэмэгдүүлэх боломж болон ажилтнуудын сургалт, хөгжлийн төлөвлөгөө зэргээр ярилцаж, санал солилцсон.

Бадрах Энержи компанийн ажилтнууд төлөөлөл 2 жил тутам сонгодог. Ажилтнуудын төлөөлөл болон компанийн удирдлагын хооронд хамтын гэрээг байгуулан ажиллаж байгаа бөгөөд гэрээг

2 жил тутам сунгадаг. Гэрээний дагуу улирал тутмын хурлаар ажилтнуудын төлөөлөл болон компанийн удирдлагаас гарсан асуудал, сэдвийн дагуу ярилцаж, шийдвэрлэн ажиллаж байна.



## Хөдөлмөрийн нөхцөлийн чанар

Хээрийн ангид ажилтнуудыг чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэхэд зориулсан бие бялдаржуулах өрөө, сагсан бөмбөгийн талбай, билльярд, ширээний теннис тоглох нөхцлүүдийг бүрдүүлсэн байдаг.



Хамтын гэрээний дагуу Бадрах Энержи компани нийт ажилтнуудынхаа эмчилгээний зардлыг 100 хувь, харин гэр бүлийн гишүүдийн, тухайлбал 21 нас хүртэлх хүүхдийн хамт эмчилгээний зардлын 80 хувийг нөхөн төлөх эрүүл мэндийн нэмэлт даатгалд хамруулдаг.

## Цалингийн бодлого

Бадрах Энержи компани зах зээлийн жишиг цалингаас өндөр цалин олгодог.

Жил тутмын цалингийн нэмэгдэл, гурван төрлийн урамшуулал, найман төрлийн нэмэгдлээс гадна компани ажилтнууддаа банкнаас хөнгөлөлттэй нөхцлөөр зээл авах боломж бүрдүүлж өгдөг.

## Зайнаас ажиллах

КОВИД-19 цар тахлаас шалтгаалсан хөл хорио эхэлмэгц Бадрах Энержи компани бүх ажилтнууддаа гэрээсээ буюу зайнаас ажиллах боломж бүрдүүлсэн. Хөл хорионы нөхцөл сулрахад ажилтнууд долоо хоногт хоёр өдөр хүртэлх хугацаагаар оффистоо ирж ажиллах болсон. Жирэмсэн эмэгтэйчүүд болон 12 хүртэлх насны хүүхдүүдтэй эмэгтэй ажилтнууд үргэлжлүүлэн зайнаас ажиллаж байна.



## Ажилтнуудад үзүүлж буй тэтгэмж

### Урамшуулал

Компанийн захирал болон ажилтнууд тухайн жилийн зорилт, ажлын гүйцэтгэл, ажилласан хугацаа зэргээс хамаарсан урамшуулал авахаас гадна ажилласан хугацааны урамшууллыг 3-с дээш жил компанид ажилласан ажилтнууддаа жил бүр олгодог.

### Нэмэгдэл

Компани ажилтнууддаа Улаанбаатар хот болон Сайншанд хотын оффист ажилласан өдрүүдэд өдрийн хоолны нэмэгдэл, хээрийн ангид

ажилласан өдрүүдэд хээрийн нэмэгдлийг тус тус олгодог ба Улаанбаатар хотоос хээрийн анги руу зорчих тохиолдолд замын хүнсний мөнгийг мөн олгодог.

## Сайн дурын эрүүл мэндийн даатгал

Компанийн бүх ажилтнууд Сайн дурын эрүүл мэндийн даатгалд хамрагддаг ба 7 сараас дээш хугацаатай хөдөлмөрийн гэрээтэй ажилтнуудын гэр бүлийн гишүүд мөн тус даатгалд хамрагддаг.

## Цалинтай чөлөө

Компани ажилтнуудынхаа аз жаргалтай, баяр, гунигтай үеүдэд дэмжлэг болгох үүднээс дараах тохиолдлуудад цалинтай чөлөө, нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгодог. Ажилтан гэрлэлтээ батлуулах, бүл нэмэх, ажилтны хүүхэд хуримаа хийх, ажилтны гэр бүлд гашуудал тохиох зэрэгт 3-5 хоногийн цалинтай чөлөө, мөнгөн тэтгэмжийг тус тус олгодог.

## Чөлөөт цаг

Ажилтнууд хээрийн ангид бие бялдар, мэдлэг оюунаа хөгжүүлэх боломжийг олгох зорилгоор компаниас холбогдох төсвийг жил бүр баталдаг.

## Нийгмийн хамгаалал

Ажилтан өндөр насны тэтгэвэрт гарах, орон тооны цомхотголд орох, тухайн албан тушаалд ур чадвар тэнцэхгүй зэрэг шалтгаанаар хөдөлмөрийн гэрээ дуусгавар болох тохиолдолд компани ажилласан жилээс хамааруулж 12 хүртэлх сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгодог.

Мөн, компаниас тэтгэвэрт гарсан ахмад ажилтнуудаа жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, цагаан сар, ахмадын баяраар мөнгөн тэтгэлэг олгодог.

Ажилтны 16 хүртэлх насны алдрай бяцхан үрсдээ хүүхдийн баяр, шинэ жилээр гарын бэлэг гардуулдаг.

Өрх толгойлсон ганц бие эцэг, эхэд жилд нэг удаа мөнгөн тэтгэлэг олгохоос гадна ажилтны гэр бүлд эрүүл мэндийн шалтгаантай хүнд үе тохиолдсон үед нэг удаагийн санхүүгийн дэмжлэг өгдөг.

## Н. Цэвэлдорж

Бадрах Энержи ХХК-ийн ажилтнуудын төлөөллийн гишүүн, Худалдан авалтын ахлах ажилтан



### “ Ажилтнуудын саналыг удирдлагатай зөвшилцөх төлөөлөл манай компанид бий

*Компанийн ажилтнуудын төлөөлөл гэж хэн бэ, юу хийдэг хүмүүс вэ гэдгээс ярилцлагаа эхлэх үү?*

Би компанидаа 10 жил ажилласнаас сүүлийн таван жилд нь ажилтнуудын төлөөллийн гишүүнээр ажиллаж байгаа. Гишүүдийг хоёр жил тутамд ажилтнууд дотроосоо сонгуулийн зарчмаар сонгодог. Зүйрлэвэл манай компанийн үйлдвэрчний эвлэл гэсэн үг. Гишүүдийг сонгоход компанийн удирдлагын ямар ч оролцоо байдаггүй. Ажилтнууд бие биендээ санал өгөөд хамгийн их санал авсан таван хүнээ

удирдлагын өмнө өөрсдийгөө төлөөлүүлэхээр сонгодог бөгөөд үүнд компанийн хугацаатай болон хугацаагүй хөдөлмөрийн гэрээтэй бүх ажилтнуудын төлөөлөл багтсан байдаг. Манай ажилтнуудын төлөөлөл бүх ажилтнаа төлөөлөн компанийн удирдлагатай хамтын гэрээ байгуулдаг.

Тэгвэл уг гэрээнд тусгагдаагүй, мөн хөдөлмөрийн гэрээний нөхцлийг сайжруулахаар ажилтнуудын зүгээс гарсан санал санаачлагыг удирдлагын багтай зөвшилцөх замаар шийдвэрлэх нь ажилтнуудын төлөөллийн гол зорилго юм.

**Ажилтнуудын төлөөлөл энэ сонгуульд ажлаа ямар хугацаагаар амжуулах вэ?**

Хоёр жил тутам дотоод сонгуулиар эдгээр төлөөлөгчийг сонгоно. Ажилтнуудын төлөөлөл улиралдаа нэг удаа хуралдана. Хэдийгээр хөдөлмөрийн гэрээ болон хамтын гэрээ хэрэгжиж байгаа ч амьдрал юм чинь асуудал ундраад л явна. Тэр бүхнийг ярилцаж хэлэлцээд заримыг нь шийдээд явдаг. Бид дундаасаа нэгийгээ ахлагчаараа сонгодог.

**Ажилтнуудын төлөөллийн бүх санал хүсэлтийг компанийн удирдлага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх боломжтой юу?**

Тийм боломж мэдээж байхгүй. Гэхдээ бүх асуудлуудыг ярилцаад, судалж үзээд, шийдвэрлэх боломжтой саналыг хүлээн авдаг.

**Аливаа хамтын гэрээгээр компани болон ажилтны хоорондох хөдөлмөрийн гэрээгээр шууд албажаагүй харилцааг зохицуулдаг. Танай компанийн хувьд хамтын гэрээгээр ямар харилцааг илүү зохицуулж ирсэн бэ? Гэрээний үр дүнгээс тодорхой жишээ хэлнэ үү?**

Энэ гэрээгээр ажилтнуудын хөдөлмөрлөх нөхцөл, нийгмийн асуудлыг сайжруулах, сургалт болон эрүүл мэндийн зарим асуудлыг шийдвэрлэх, баталгааг хангах чиглэлээр илүү зохицуулдаг. 2019 онд байгуулсан хамтын гэрээг 2021 оны 5 дугаар сард шинэчлэн байгуулаад эдүгээ ажилтнуудын төлөөллийн багт орох хүмүүсээ манай ажилтнууд сонгоод байна. Манай ажилтнуудын цалин жил тутам нэмэгдэж ирсэн. Энэ маань хамтын гэрээний хэрэгжилтийн маш тодорхой үр дүн. Хамтын гэрээнд цалингийн нэмэгдлийн талаар тусгасан байдаг. Монгол улсын эдийн засгийн байдал, өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт, инфляци, ажлын үр дүн, мэргэжлийн ур чадвар зэрэг олон хүчин зүйлийг харгалзаад нэмдэг. Намайг 10 жил ажиллах хугацаанд хамтын гэрээний хэрэгжилтийн хүрээнд бидний цалин жил бүр өссөөр л ирсэн. Нэмэгдээгүй жил нэг ч байгаагүй. Ажилтнуудын төлөөлөл цалин нэмэгдлийн талаарх ажилтнуудын санал хүсэлтийг илэрхийлж ирсэн. Компанийн удирдлага мэдээж ажилтнуудаа сонсоно. Мөн хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн хөдөлмөрийн хөлсний судалгаанд үндэслээд инфляци болон бусад олон хүчин зүйлийг харгалзан эцсийн шийдвэрийг гаргадаг.

**Ажилтнуудын төлөөлөөр дамжуулаад компанийн удирдлагын шийдвэрлэсэн сүүлийн үеийн жишээ гэвэл юу вэ?**

2020 оны 2-р улирлаас Ковид-19-ийн улмаас сургууль, цэцэрлэг хаагдсантай холбоотойгоор ажилтнуудад гэрээс ажиллах боломж олгохыг хүсэхэд манай компанийн удирдлага тухайн үед нааштайгаар шийдвэрлэн долоо

хоногийн зарим өдрийг зайнаас буюу гэрээс ажиллахыг зөвшөөрсөн тушаал гаргаж байсан. Тухайн үед Улаанбаатар хотын захирагч бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүдэд гэрээс ажиллах боломж олгохыг ажил олгогчдод уриалж байсан л үе, харин манай компани ийнхүү ажилтнуудаа зайнаас ажиллах зохицуулалт хийсэн аж ахуйн нэгжүүдийн анхдагчдын нэг гэдэгт итгэлтэй байна. Мөн хамтын гэрээтэй холбоотой нэг зүйл нэмээд хэлэхэд ажилтнуудынхаа эрүүл мэндийн асуудалд манай байгууллага онцгой анхаарал халамж тавьдаг. Тухайлбал, жил бүрийн эрүүл мэндийн үзлэгийг маш нарийн, цогц байдлаар чанартай сайн зохион байгуулдаг. Мөн ажилтнуудынхаа гэр бүлийн гишүүдийг эрүүл мэндийн давхар даатгалд даатгуулдаг. Ажилтан өвдөөд эмчилгээ үйлчилгээний зардал гарсан бол даатгалаас тухайн зардлыг нь 100 хувь, харин гэр бүлийн гишүүд эмчлүүлсэн бол нийт зардлын 80 хувийг нөхөн олгодог.

**Францчууд нийгмийн асуудалд их анхаардаг улс. Тэгэхээр энэ Орано группийн хэмжээнд хэрэгждэг соёл байх даа. Танай компанид ажилтнуудынхаа эрүүл мэндийн төлөөх энэ мэт анхаарал халамж хэр удаан хэрэгжиж байна вэ?**

Энэ тогтолцоо манай компанид олон жил болж байгаа. Орано группийн хэмжээнд хэрэгждэг том соёл. Гэхдээ тогтоосон хязгаар бий. Шүүд эмчлүүлэхэд, харааны нүдний шилний засвар үйлчилгээ буюу худалдан авалт гэх мэт зарим нөхөн төлбөрт жилийн дээд хязгаарыг заасан байдаг. Ажлын байран дээр осол гэмтэлд орсноос эрүүл мэндээрээ хохирох, тодорхой хугацаад хөдөлмөрийн чадвараа алдах гэх мэт асуудлыг тусдаа хөдөлмөрийн тухайн хуулийн дагуу ажил олгогчийн хариуцлагын даатгалаар зохицуулахаар тусгасан байдаг.

**Ингэхэд Та бүхний боловсрол мэдлэгт хэр хариуцлагатай хандаж байна?**

Компанийн зүгээс ажилтнуудаа боловсрол мэдлэгийг нь дээшлүүлэх, чадавхжуулах сургалтад байнга хамруулдаг. Энэ талаар манай ажилтнуудын зүгээс ч жилийн эцсийн ярилцлагын үеэр санал гаргаж болдог. Дээрээс нь группийн болон манай компанийн хүнийн нөөцийн бодлого маш сайн хэрэгждэг гэж бид боддог. Тухайлбал гадаад, дотоодод богино хугацаагаар сургахаас эхлээд мастер, докторын сургалтад хүртэл хамруулдаг.

**Ажилтнуудын төлөөлөл компанийн удирдлагад санал тавьж байж асуудлаа шийдвэрлүүлсээр ирсэн үү? Компанийн удирдлагын зүгээс ажилтнуудаа дэмжсэн саналыг та бүхэнд тавьдаг уу?**

Бидэнд компанийн зүгээс ажилтнуудын нийгмийн зарим асуудлыг сайжруулах санал ирүүлээд шийдвэрлэж байсан тохиолдол бий.

ЯРИЛЦЛАГА...

# 4 | ЭРҮҮЛ МЭНД, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЦАЦРАГИЙН ХАМГААЛАЛТ

Бидний эрхэм зорилго бол ажилтнуудынхаа эрүүл мэндийг хамгаалж, аюулгүй байдлыг хангах явдал юм. Энэ нь компанийн үйл ажиллагаан дахь аюулгүй байдалд хамаарах эрсдлийг тогтоон, удирдахыг хэлнэ.



**Орано Майнинг компанийн ажилтнууд чулуулаг өрөмдөх, тэслэх, хүнд тоног төхөөрөмж, химийн бүтээгдэхүүн ашиглах, хөдөлгүүрт хэрэгсэлтэй харьцах, өндөрт ажиллах, зорчих ба ионжуулагч цацрагт өртөх зэрэгтэй холбогдсон чиг үүргүүдийг хэрэгжүүлдэг.**

Бадрах Энержи ХХК нь Орано группийн эрүүл мэнд, аюулгүй байдал ба цацрагийн хамгаалалтын бодлогыг мөрдөж, үйл ажиллагаагаа дээрх бодлоготой уялдуулан нийцүүлж, олон улсын жишгийг нэвтрүүлэн ажилладаг. Үүнд:

- Аюулгүй байдлын соёл ба манлайлал
- Үндсэн зарчмуудыг дагаж хэрэгжүүлэх
- Зохион байгуулалт ба ур чадвар
- Эрсдэлээс урьдчилан сэргийлэлт багтана.

Дараах зорилгоор олон тооны сургалтын болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Хөдөлмөрийн аюулгүй байдлын өндөр стандартыг баталгаажуулан баримтлах
- Ноцтой болон ажилтны амь нас эрсдэх ослоос урьдчилан сэргийлэх
- Ажлын зогсолттой осол гаргалгүй, компанийн ажилтан, хамтран ажиллагч компанийн ажилтан болон компанийн үйл ажиллагаа явагдаж байгаа газрын ойролцоо амьдардаг хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдалд компанийн үйл ажиллагааны нөлөөлөл үзүүлэхгүй байх нь манай компанийн байнгын зорилтууд юм.

Бадрах Энержи ХХК Эрүүл мэнд, ХАБ-ын бодлогоо удирдлагын тогтолцоогоороо дамжуулан хэрэгжүүлдэг. Уг бодлогод үйл ажиллагаа явагдаж байгаа улсын болон нутгийн тодорхой онцлог хийгээд холбогдох тогтоомжийг тооцохын сацуу ISO OHSAS 18 001 стандартын шаардлага эсвэл түүнтэй адилтгах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, цацрагийн хамгаалалтын хөтөлбөрийг мөрдөж ажилладаг. Ингэхдээ хэмжигдэхүйц үр дүнг компанийн бүх сайтууд дээр тооцож дүгнэдэг.



## Эрүүл мэнд

**Бадрах Энержи компани ажилтнуудынхаа эрүүл мэндийн хамгааллыг бэхжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.**

Ажилтнуудынхаа эрүүл мэндийг сахин хамгаалах зорилгоор эрүүл мэндийн багаа дараах үндсэн зорилгод чиглүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах
- Эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, мэдлэг олгох сургалт сурталчилгаа зохион байгуулж, мэдээллээр ханах
- Эрүүл мэндийн хугацаат болон урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмол зохион байгуулснаар ажилтнуудынхаа эрүүл мэндийг хянах
- Шинэ ажилтны эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулах
- Ажилтнуудыг сайн дурын урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулах ажлыг зохион байгуулах
- Хээрийн анги дээр эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээг үзүүлэх, шаардлагатай тохиолдолд эмнэлэгт шилжүүлэх зэрэг багтана.

## Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлт

Компанийн нийт ажилтнууд УБ-Сонгодо эмнэлэгт жил тутмын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагддаг. Үзлэгийн төгсгөлд мэргэшсэн

эмч нар ажилтнуудад зөвлөгөө өгч, шаардлагатай эмчилгээг мөн санал болгодог.

Үүний зэрэгцээ компанийн хээрийн ангид цацрагтай харьцдаг тодорхой тооны ажилтнууд Мэргэжлээс шалтгаалах өвчний үндэсний төвд жил бүр үзлэгт хамрагддаг.

- 2017 онд 85 ажилтан
- 2018 онд 71 ажилтан
- 2019 онд 64 ажилтан
- 2020 онд 48 ажилтан тус тус хамрагдсан ба мэргэжлээс шалтгаалсан ямар нэг өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна.

## Хээрийн анги дээрх яаралтай тусламжийн бүтэц

Бадрах Энержи компани хээрийн ангидаа байнга их эмч ажиллуулдаг. Эмч нар компанийн ажилтнууд төдийгүй нийт гэрээлэгч компанийн ажилтнуудад эмнэлгийн яаралтай тусламж үзүүлдэг. Компанийн эмч нар мөн хээрийн ангийн эрүүл ахуй, ариун цэвэрт хяналт тавьж ажилладаг.

Бадрах Энержи компани эрүүл мэндийн яаралтай тусламж авах гэрээг Сонгодо эмнэлэгтэй хийж хамтран ажилладаг. Мөн тус эмнэлгээс зөвлөх эмч ажиллуулж, компанийн эмч нартаа зөвлөгөө өгүүлж, мэдлэг чадварыг нь дээшлүүлэхэд анхаардаг.

Компанийн хээрийн анги эмнэлгийн анхны тусламжийн тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан. Мөн анхны тусламж үзүүлэх зориулалтын байр болон яаралтай тусламжийн машинтай.



### Сайн дурын дархлаажуулалт

Бадрах Энержи компани жил бүр ажилтнуудаа сайн дурын томуугийн дархлаажуулалтад хамрагдах боломжоор хангадаг. Ингэснээр ажилтнууд тухайн жил томуу, томуу төст өвчнөөр өвчлөх нь харьцангуй багассан үр дүнтэй байна. Дархлаажуулалтыг жил бүрийн 9–10 дугаар сард Халдварт өвчин судлалын үндэсний төвтэй хамтран зохион байгуулдаг. **2019 онд 41 ажилтан вакцинжуулалтад хамрагдаж байсан бол 2020 онд нийт 61 ажилтан хамрагдсан. 2021 онд бүх ажилтнууд дархлаажуулалтад хамрагдсан.**

### Эрүүл мэндийн зөв дадлыг сурталчлах сургалт

Компанийн эрүүл мэндийн багийнхан улирлын чанартай гардаг өвчлөл, түүнээс урьдчилан сэргийлэх дараах сургалт мэдээллийг ажилтнуудад байнга өгч ажилладаг. Үүнд:

- Ханиад томуу, гэдэсний халдварт өвчлөлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх,
- Хатиг халдвар, наршилт, харшил, гэдэсний хэвийн бичил бактерийн талаарх ойлголт,
- Эрүүл амьдралын хэв маяг, түүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө,
- Тамхи, таргалалт, хөдөлгөөн дутагдлын хор хөнөөл,
- Зүрх, судасны өвчлөл, түүний хор уршгийн талаарх сургалтыг зохион байгуулсан байна.

## Хөдөлмөрийн аюулгүй байдал

Бид ажлын зогсолтод хүргэх ослыг гаргалгүй, компанийн үйл ажиллагаанаас шалтгаалан үндсэн болон гэрээт ажилтнууд, мөн ажлын талбайн ойр орчимд амьдардаг иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй байх ганц зорилго тавин ажиллаж байна.

Компанийн ажилтнууд үйлдвэрийн талбай, ажлын байр, эсвэл Орано Майнинг компанийн салбаруудад томилогдон ажиллахдаа эрүүл мэндэд нь нөлөөлөх эрсдэлийн хэд хэдэн хүчин зүйлд өртөх магадлалтай байдаг.



Тиймээс эрсдэлээс сэргийлж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эерэг үзүүлэлтийг өндөр түвшинд тогтмол хадгалах зорилгоор олон тооны мэдээллийн болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Ослоос шалтгаалсан ажлын зогсолт 2018, 2019 онд тохиолдоогүй. 2020 оны дунд үе хүртэл нийт 1782 өдөр ажлын зогсолттой осолгүй маш амжилттай ажилласан. 2020 онд гэрээт байгууллагын ажилтан осолд өртөж, 14 хоног эрүүл мэндийн чөлөөтэй байсан. Тус ослын талаарх мэдээллийг нийт ажилтнуудад танилцуулж, сэрэмжлүүлэх арга хэмжээг авсан.

KPI	2018	2019	2020
Fatality	0	0	0
LTI	0	0	1
MTI	0	0	0
LTIFR	0.00	0.00	3.85
TRIFR	2.09	0.00	7.70

*Fatality: Ажлын байранд ажилтан амь нас эрсэдсэн осол.*

*LTI: (Lost Time Injury) Ажил зогсолттой осол*

*MTI: (Medical Treatment Injury) Эмнэлгийн тусламж авсан тохиолдол*

*LTIFR: Ажлын зогсолт үүсгэсэн ажлын байрны ослын давтамжийн түвшин*

*TRIFR: Ажлын зогсолттой ба зогсолтгүй ажлын байрны ослын давтамжийн түвшин*

## Ажлын үр дүн

Бид жил болгон ХАБЭА–н тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, бусад дүрэм, журам, батлагдсан стандартын тухай мэдлэг, ойлголт өгөх тусгай зөвшөөрөл бүхий сургалтад нийт ажилтнуудаа заавал хамруулдаг.

2020 онд Ковид–19 цар тахлаас шалтгаалан жил бүрийн аюулгүй байдлын өдөрлөгийг зохион байгуулаагүй хэдий ч, ХАБ–ын багийнхан 5 зарчим, 7 стандарт танилцуулах ажлыг 2020 оны туршид хийсэн. Өндөр эрсдэл бүхий нөхцөл байдлыг илрүүлэх (HIPO), үр дагавар, шалтгаанд дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллав.

Гарсан ослуудыг бүртгэн нийт ажилтнуудад сэрэмжлүүлэхээс гадна АHEAD системд оруулан группийн бусад уул уурайн компаниудад мэдээлдэг. Сар бүр ажилласан цагийн бүртгэл хөтөлж ослыг дээрх байдлаар дүгнэн ХАБ–ын үзүүлэлтээ дүгнэдэг.

## Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээ

2020 оноос Ковид–19 халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг цогцоор хэрэгжүүллээ

Бадрах Энержи компани 2020 оны 2 дугаар сард Ковид–19 халдвараас урьдчилан сэргийлэх халдвар хамгааллын дотоод журмуудаа боловсруулан ажилтнуудаа танилцуулж, санамж анхааруулгыг нийтийн газар байршуулан, халдвар хамгааллын дэглэмийг чандлан сахиж хэрэгжүүллээ.

Компанийн зүгээс ажилтнуудаа амны хаалт, гар ариутгагч, түргэвчилсэн тест, халдвар хамгааллын хувцас хэрэгслээр тасралтгүй тогтмол хангаж ирлээ.

2020 оны 11 дүгээр сард Ковид–19 вирусны халдвар дотоодод тархсантай холбоотойгоор хээрийн ангид тусгаарлах журам гарган, тусгаарлах байранд 5–7 хоног тусгаарлаж, хээрийн ангийг ковидгүй бүс байлгах зорилгоор түргэвчилсэн тестээр шинжилгээг авч, халдвараас урьдчилан сэргийлэн ажиллаж байна.



## Осолд дөхсөн тохиолдлын удирдлага

Бадрах Энержи компани осолд дөхсөн тохиолдлыг бүртгэж, мэдээлснээр болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулж байна.

- 2018 онд осолд дөхсөн 9 тохиолдол бүртгэгдсэн ба түүнээс гурвыг нь өндөр эрсдэлтэйд тооцож бүртгэж судалсан.
- 2019 онд осолд дөхсөн 5 тохиолдол бүртгэгдсэн.
- 2020 онд осолд дөхсөн тохиолдол 5 бүртгэгдсэн байна.

Компанийн зүгээс төслийн талбай болон ажлын байранд гэнэтийн осол гарах, байгалийн гамшиг, гал түймрийн аюулын үед ямар арга хэмжээ авах, яаралтай анхны тусламж хэрхэн үзүүлэх, онцгой байдлын үед ажиллах баг хэрхэн, яаж ажиллах зэрэг сургалт, сургуулийг улирал тутам хийж хэвшүүлээ.

Ажлын талбай дээр гарахын өмнө бүх ажилтанд өглөө бүр ахлах мэргэжилтэн зааварчилгаа өгдөг. Мөн галын аюулгүй байдлын дадлагажуулах сургалт, онцгой байдлын үеийн болон ажилд шинээр орсон хийгээд шилжин ирсэн ажилчдын зааварчилгаа, зочдын аюулгүй ажиллагааны зааварчилгааг таниулах ажлыг зохион байгуулж ажилладаг.



## ХАБ-ын сургалт

2020 онд:

- Нийт ажилтны дунд 14 цагийн сургалтыг ХАБЭА-н тухай хуулийн дагуу зохион байгуулсан.
- Химийн хортой ба аюултай бодистой харьцах аюулгүй ажиллагааны 14 цагийн сургалтыг туршилтын үйлдвэрт ажиллах нийт оператор, туслах, жолооч нарт зохион байгуулсан.
- Цөмийн энергийн тухай хууль болон Цөмийн энергийн комиссын тогтоолын дагуу цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын мэдлэг олгох сургалтад туршилтын үйлдвэрт ажиллах нийт ажилтнаа хамруулсан.
- Дизель хөдөлгүүрийн засвар үйлчилгээний сургалтад 2 цахилгаанчин хамрагдсан.
- Өндөр хүчдэлтэй ажиллах сертификаттай сургалтад цахилгаанчин хамрагдлаа.

## Онцгой нөхцөл байдлын дасгал сургууль

Туршилтын үйлдвэрт гарч болох аюул, эрсдэлүүдийг үнэлэх замаар тохиолдож болох нийт ослын мэдээлэл бүхий шуурхай ажиллагааны 10 хуудас гаргаж, дадлага хосолсон сургалтууд зохион байгуулсан. Туршилтын үйлдвэрийн хэмжээнд химийн бодис, галын аюулгүй байдлын ослын сургалтыг 2020 оны 1, 2 дугаар сард зохион байгуулав.



## С. Мөнхбаатар

Бадрах Энержи ХХК-ийн ХАБ,  
цацрагийн хамгаалал хариуцсан  
супервайзор



“ **Бид аюулгүй ажиллагааны 10 алхмаа шалгаж байж ажлаа эхлүүлдэг** ”

*Танай компани Дорноговь аймагт ажиллаж эхэлснээс хойш чамгүй олон жил боллоо. Энэ хугацаанд ямар нэг ноцтой аюул осол гарсан уу?*

Бадрах Энержи ХХК Дорноговь аймагт үйл ажиллагаагаа эхэлснээс хойш хүний амь эрсэдсэн осол болон хөдөлмөрийн чадвараа алдсан осол эндэгдэл гаргаагүй өнөөдрийг хүрсэн байна. Мөн 2015 оноос хойш ажлын зогсолттой осол тохиолдсонгүй. Харин 2020 онд манай туслан гүйцэтгэгч компанийн нэг ажилтан гараа гэмтээгээд эмнэлгийн тусламж авсан юм. Хэдийгээр манай үндсэн компанийн бус туслан гүйцэтгэгч байгууллагын ажлын хүрээнд тохиолдсон ч гэсэн Орано группийн журмаар

энэ ослыг бид өөр дээрээ бүртгэж авсан. Энэ нь өөрийн төдийгүй туслан гүйцэтгэгч компаниудынхаа ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд тавих анхаарал шаардлагыг өндөржүүлэн хамгаалж ирсэн манай компанийн бодлогын нэг илрэл юм.

*ХАБЭА-г бүрэн хангаж ажиллахад хамгийн чухал зүйл нь юу вэ?*

Юуны өмнө удирдлагаас эхлээд менежер, ажилтан гээд компанийн бүх түвшинд хамт ажиллаж байгаа нөхдийнхөө эрүүл мэнд, аюулгүй байдлыг эн тэргүүнд тавьж, анхаарал хандуулж ХАБ-ын соёлыг компанидаа бүрэн нэврүүлэх

нь амжилтын гол үндэс гэж бодож байна. Хүн бүр өглөө ажилдаа ирэхдээ орой эрүүл саруул гэртээ харих итгэл үнэмшил, хариуцлагатай ажилладаг. Энэ соёлыг ч бид төлөвшүүлсээр ирсэн. Тухайлбал, эрсдэлийг ажлын байран дээрээ үнэлэх “Өврийн дэвтэр”-ийг ажилтан бүр тогтмол хөтлөх боломжийг бүрдүүлсэн.

Ажлын аюулыг үнэлэх энэхүү өврийн дэвтрийг тухайн ажил гүйцэтгэх ажилтан ажлаа эхлэхийн өмнө бөглөж, ХАБ-тай холбоотой 10 асуултын дагуу эрсдэл бүрийг нягтлан шалгаж хариулах замаар өөрийгөө болон бусдыг эрсдэл, ослоос хамгаалдаг. Өөрөөр хэлбэл тухайн 10 алхмыг нэг бүрчлэн шалгаж, аюулгүй ажиллагааны хувьд бэлэн болсны дараа ажлаа эхлүүлдэг гэсэн үг. Өндөрт ажиллах зөвшөөрлөө аваагүй бол эхлээд түүнийгээ авах, хамгаалах хэрэгсэл дутуу бол гүйцээх гэх мэтээр эрсдэлгүй орчныг бий болгох зорилгоор хөтөлдөг энэхүү “Өврийн дэвтэр”-ийг бид 2015 оноос хойш байнга ашиглаж байна.

Манай хамт олон ч энэ зарчмыг хэрэгжүүлээд, ямар нэг дутуу зүйл байвал цаг тухайд нь хэлж шаардаад сурчихсан. Үүний дагуу компанийн зүгээс ажилтан бүрийнхээ аюулгүй байдлыг хамгаалахад шаардлагатай хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж байдаг.

**Уул уурхайн компанийн үйл ажиллагаанд авто машины хөдөлгөөнтэй холбоотой осол зөрчил нэлээд өндөр хувийг эзэлдэг. Танайх замын хөдөлгөөнтэй уялдуулж ямар арга хэмжээ хэрэгжүүлдэг вэ?**

Манай компани бүх авто машиндаа GPS буюу газар зүйн байршлын систем суурилуулж, Монгол улсад зөвшөөрөгдсөн хурдны хязгаараас ч багасгасан стандартыг жолооч нартаа мөрдүүлдэг. Тухайлбал, хээрийн ангиудын ойр орчимд 30 км/цаг, харин тэдний хооронд болон өөрсдийн үйлдвэрийн замд 60км/цаг хурдтай явна гэх мэтээр хурдны хязгаарыг тогтоосон. Хэрвээ хурд хэтрүүлбэл тухайн машины мэдээлэл хяналтын компьютер дээр бүртгэгдэж, жолоочид анхааруулах, сургалт мэдээллийг давтан өгөх журам хэрэгждэг. Ингэснээр орон нутгийн замд мал амьтан дайрах, худаг усны байгууламжийг дайрч эвдэх гэх мэт бусад уурхайд мэр сэр гардаг осол зөрчлөөс бүрэн урьдчилан сэргийлж ажиллаж байна.

Цаашид ч үйл ажиллагаа явуулж байгаа нутгийн иргэдийн амьдралын таатай орчинд саад учруулахгүйн тулд дээрх шаардлага биелүүлсээр байх болно.

**Та бүхэн Монгол улсын хэмжээнд мөрддөг ХАБЭА-н хууль дүрмийг мэдээж мөрддөг байх. Түүний зэрэгцээ өөр ямар журам мөрддөг вэ?**

Бид ХАБ-ын 12 стандарт баримталж байгаад 2018 оноос 5 зарчим 7 стандарт мөрдөж хэвшүүлсэн.

Энэ 5 зарчим 7 стандарт нь Орано группийн бүх уул уурхайн нэгж, салбарт мөрдөгддөг. Мөн группийн хэмжээний уул уурхайн төсөл болон салбар нэгжүүдэд гардаг осол эндэгдлийн судалгааг гаргаж, анхаарах шаардлагатай асуудлуудыг дээрх зарчим, стандартын хүрээнд тодорхойлж, бусад бүх салбарт мэдээлж, бүхий л туршлагаасаа харилцан суралцаж, урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авдаг.

Ийнхүү туршлага солилцох нь маш үр дүнтэй байдаг. Бид 5 зарчим, 7 стандартаа мөрдөж ажилласнаар хүний амь эрсдэх болон хөдөлмөрийн чадвараа алдах ноцтой ослоос бүрэн сэргийлэх боломжтой юм. Эдгээрийг нийт группийн хэмжээнд тохиолдож байсан осол болон осолд дөхсөн тохиолдлуудын судалгаанд үндэслэж тодорхойлсон. Жишээлбэл, энэхүү зарчим стандартын дагуу ямар нэгэн гэмтэлтэй тоног төхөөрөмж болон техник хэрэгсэлд засвар, үйлчилгээ хийхдээ бусад ажилтныг аюул эрсдэлд өртөхөөс сэргийлж цахилгааны эх үүсвэрийг салгах болон тухайн орчныг заавал тусгаарлаж цоожлох, пайзлах системийг хэрэгжүүлж хэвшүүлсэн.

Манай хамт олон ХАБ-ын эдгээр дүрэм зарчмаа цаашид улам сайн чанд мөрдөж, ажлын байрны осол эндэггүйгээр ажиллаж чадна гэдэгт бүрэн итгэлтэй байна.



\* ХАБ-ын зарчим бол хүн бүрийн өдөр тутмын ажлын салшгүй хэсэг ба компанийн удирдлагаас тэдгээрийг хэрэгжүүлэхэд онцгой анхаардаг. Аливаа ноцтой болон амь эрсдэсэн осол гэмтэлд өртөх эрсдэлтэй ажилтнууд, түүнчлэн гэрээлэгчид бүгд эрсдлээс урьдчилан сэргийлэхийн тулд ХАБ-ын зарчмаа ягштал мөрдөх ёстой.

\*\* ХАБ-ын стандартууд нь ХАБ-ын зарчмуудыг хэрэгжүүлэх үндсэн тулгуур юм. ХАБ-ын стандартад эрсдэлийг хянах болон ослоос урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлдэг дүрэм журам эсвэл шилдэг туршлагууд хамаарна.

ЯРИЛЦЛАГА...

## Цацрагийн хамгаалалт

Монгол улсын Цөмийн энергийн тухай хууль, үндэсний болон олон улсын норм, дүрэм журам, стандартуудыг Бадрах Энержи компани хэрэгжүүлж ажилладаг.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин хамгаалалт, цацрагийн хамгаалалтын талаар баримтлах бодлогоо Бадрах Энержи компани 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдөр шинэчлэн баталсан. Уг бодлогод компанийн болон гэрээт аж ахуйн нэгжийн ажилтнуудын цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг бүрэн хангах зорилгоор цацрагийн хамгаалалтын үйл ажиллагааг төлөвлөж, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллахын зэрэгцээ цацрагийн хувийн тунгийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана гэж заасан.

**Цацрагийн хамгаалалт, хяналтын зарчмаар**

Цацрагтай ажиллагчийн бүлэг	Хүн амын бүлэг
Хяналтын бүсэд байнга болон тодорхой хугацаагаар ажилладаг.	Цацраг идэвхт ураны хүдэртэй шууд харьцаж ажиллахгүй.
<b>Нийт 41 ажилтан</b>	<b>Нийт 45 ажилтан</b>



2020 онд Бадрах Энержи компани Зөвөч–Овоо ордод туршилтын үйлдвэрийн үйл ажиллагаа явуулах холбогдох зөвшөөрлийг авсан бөгөөд туршилтыг 11 дүгээр сарын 5–6-ны өдөр 2010–2011 оны Өмнөдийн туршилтаар гарган авсан давирхайд наалдуулсан ураны боловсруулалтаар эхлүүлсэн. Үүний өмнө туршилтын үйлдвэрийн байгууламжуудын хэмжээнд хяналтын бүсийг тодорхойлж, шаардлагатай тэмдэг тэмдэглэгээ, анхааруулах санамж зэргийг байрлуулж, ажилтнуудад мэдээлэл сургалтыг хийж таниулсан. Хяналтын бүсэд зөвшөөрөлгүй нэвтрэх боломжгүй ба зочин нэвтрэх тохиолдолд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны зааварчилгааг урьдчилан өгч, хамгаалах, хувцас хэрэгслээр хангаж, нэвтрэх эрх бүхий ажилтанг дагалдуулан нэвтрүүлдэг.

### Мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналт

Компани цацрагтай ажиллагсдыг ионжуулагч цацрагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор хувийн тунгийн дозиметрийн хяналтад тогтмол хамруулдаг. Хяналтын дүнгээс харахад холбогдох хууль, дүрэм, журам, нормд заасан хязгаараас хэтэрсэн тохиолдол гараагүй.

Цацрагтай ажиллагчийн бүлэгт хамаарах ажилтнуудаас нийт 41 ажилтан хяналтын бүсэд ажилласан ба дундаж тун нь 0.1 мЗв/хүн байв.

Энэ жилд бүртгэгдсэн хамгийн өндөр тун нь 0.25 мЗв/хүн байв. 2020 онд гэрээлэгч байгууллагын 8 ажилтан хяналтын бүсэд ажилласан тул мөн дээрхи хяналтанд хамрагдсан.

Гэрээлэгч байгууллагын ажилтнуудын дундаж тун нь 0.15 мЗв/хүн, хамгийн өндөр тун нь 0.3 мЗв/хүн тус тус бүртгэгдлээ.



## I Хүн амын хяналт

Бадрах Энержи компанийн Зөвөч-Овоо туршилтын үйлдвэр байгаа нутгийн орчимд хүн амын нягтрал нэн сийрэг. Нэг хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэрт 0.13 хүн ноогдоно. Компани ажилтнуудынхаа мэргэжлийн шарлагын тунг хянахын зэрэгцээ тухайн бүс нутгийн ард иргэдийн авч буй цацрагийн шарлагын тунгийн хэмжээг мөн хянах зорилгоор төслийн талбайн 5, 10, 15, 20 км-ийн радиуст төлөөлөл болгон авсан цэгүүдэд сард нэг удаагийн давтамжтайгаар тунгийн чадал, гадаргуун бохирдлын хэмжилтийг хийж гүйцэтгэдэг. Үр дүнгээс харахад байгалиас авах гадаад шарлагын тунгийн хэмжээ 0.6 мЗв/жил байгаа нь 2,4 мЗв/жил болох дэлхийн дундаж хэмжээнээс даруй 4 дахин бага байгаа нь компанийн үйл ажиллагаанаас шалтгаалсан цацрагийн нэмэлт шарлага үүсээгүйг баталж байна.



нийгэмлэгээс зохион байгуулсан цацраг хамгаалалт, аюулгүй байдлын сургалтад хамруулсан. Тус сургалтад Бадрах Энержи ХХК, гэрээт компанийн цацрагтай шууд харьцаж ажиллаж байгаа ажилтнууд болон бусад ажилтан хамрагдсан.



## I Хамгаалах хэрэгсэл, тэдгээрийн ашиглалт

Бадрах Энержи ХХК болон гэрээлэгч компаниуд нь ХАБЭА-н тухай хуулийн 15-р зүйлд заасны дагуу ажилтны ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр бүх ажилтнаа хангаж ажилладаг. Байгалийн цацраг идэвхт материалтай харьцах болон хяналтын бүсэд ажиллахдаа биеийн хэсгүүдийг болон гараа бохирдлоос сэргийлэх зорилгоор ажлын хувцас, амны хаалт, бээлийг заавал хэрэглэхийг шаарддаг. Мөн цацрагтай ажиллагчдын бүлэгт хамаарах ажилтан бүр ажлын байран дээрээ хувийн цацрагийн шарлага хэмжих багаж буюу дозиметр зүүх үүрэг хүлээдэг.

## I Цацрагийн хамгаалалтын сургалт

Цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу Бадрах Энержи компани өөрийн ажилтнууд, дадлагын оюутан, гэрээлэгч компанийн ажилтнуудад цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод сургалтыг зохион байгуулж, бүртгэл хөтлөн баталгаажуулж ажилласан. 2020 онд сургалт, зааварчилгаанд компанийн 66 ажилчид, 16 зочин, гэрээлэгч байгууллагын 30 ажилтан хамрагдсан.

Монгол Улсын Цөмийн энергийн тухай хуулийн 36.1.7-р зүйлд заасны дагуу нийт 64 ажилтныг 2020 онд Монголын цацрагийн хамгаалалтын

## I Цацрагийн хяналт

### Ажлын байрны цацрагийн хяналт

Цацрагтай холбогдолтой үйл ажиллагаа эрхэлж буй компанийн цацрагийн аюулгүйн албаны дүрэм болон тус компанийн цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэмд зааснаар гамма цацрагийн тунгийн чадал, гадаргуун бохирдлын хяналтын хэмжилтийг ажилтнуудынхаа ажлын болон амралтын байранд хуваарийн дагуу тогтмол хийж, үр дүнд нь хяналт тавьж ажиллаж ирэв.

Хэмжилтийн үр дүнгээс харахад ажил болон амралтын байруудад гамма цацрагийн тунгийн чадал байгалийн фон утга 0.2 микроЗиверт/цаг-тай ойролцоо байна. Харин боловсруулах үйлдвэр дотор урантай давирхайг салгах хэсэгт хамгийн өндөр тунгийн чадал хэмжигддэг ч тус ажлын байранд 8 цаг ажилласнаар ажилтны авах жилийн эффектив эквивалент тунгийн хэмжээ нь »1.10 мЗв/ж байх бөгөөд энэ нь Монгол улсын эрх зүйн зохицуулалтын дагуу цацрагтай ажиллагсад тавигддаг тунгийн хязгаар хэмжээ буюу 20 мЗв/ж –аас даруй 20 дахин бага байна.

### Агаар дахь радоны хяналт

Байгууллагын ажлын болон бусад байрны агаар дахь аэрозоль ба цацраг идэвхт хийн агууламжийг хянаж байхаар заасны дагуу Бадрах Энержи компани агаар дахь радоны хяналтыг 2 долоо хоног тутам, сар тутам, 2 сар тутам гэсэн давтамжтайгаар хийж гүйцэтгэж ирлээ.

Тухайн ажлын байрны онцлог болон эрсдлийн зэргээс хамаарч давтамжийг тодорхойлдог. Тухайлбал, радоны хуримтлал хамгийн их байж болох уран агуулсан давирхай хадгалах байранд хамгийн өндөр нь 149 Бк/м3 гэж бүртгэгдсэн ба энэ цацрагтай ажиллагсдын ажлын байранд зөвшөөрөгдөх хэмжээ болох 1110 Бк/м3 –аас даруй 7 дахин бага байна.

### Байгаль орчны цацрагийн хяналт

Бадрах Энержи компани хүрээлэн буй орчны цацрагийн дэвсгэр түвшинг хянах, холбогдох стандартын зөвшөөрөгдөх хэмжээтэй харьцуулах, ажиглалт хийх зорилгоор хөрс, гүний болон гадаргын усан дахь цацраг идэвхт изотоп болон хүнд металын шинжилгээг Цөмийн судалгааны лаборатори, Геологийн төв лабораторид тус тус хийлгэдэг.



# 5 | ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭ



Бадрах Энержи ХХК худалдан авалтынхаа 97 хувийг дотоодоос буюу Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдээс хийдэг. Ингэснээр бид Монгол улсын аж үйлдвэрийн хөгжил, инноваци ба үйл ажиллагааны төгөлдөршилд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.



Бадрах Энержи компани ханган нийлүүлэлт ба худалдан авалтын үйл ажиллагаагаа байгаль орчныг хамгаалах, нийгмийн хөгжлийг дэмжих, хүний эрхийг хангах шалгуур үзүүлэлтийн дагуу зохион байгуулснаар Монгол улсын ба ард иргэдийн эдийн засгийн чадавхыг сайжруулахад хувь нэмрээ оруулж байна.

## Ханган нийлүүлэлтийн сүлжээн дэх үнэ цэн

Бадрах Энержи компани ханган нийлүүлэлтийн сүлжээндээ дараах үнэ цэнийг эрхэмлэж ажилладаг. Үүнд:

- **Чанар ба аюулгүй байдал:** Чанар ба аюулгүй байдлыг эрхэмлэх нь нийт ажилтнууд ба гэрээлэгчдийн хувьд чухал зорилт юм. Энэ ч утгаараа ажлын зогсолттой осол, хүний амь эрсэдсэн осолгүй өдрийн тоо зэрэгт гэрээлэгч, нийлүүлэгчдийн үзүүлэлтийг давхар тооцдог.
- **Хууль дүрмийн нийцэл, ёс зүй ба ил тод байдал:** Ханган нийлүүлэлт, худалдан авалт нэг бүрийг Монгол улсын төдийгүй олон улсын холбогдох хууль тогтоомж, стандарт, бусад дүрэм журмын хүрээнд хийдэг. Нийлүүлэгчидтэй байгуулж буй гэрээний салшгүй хэсэг нь Орано группийн Ёс зүйн дүрэм байдаг бөгөөд түүнийг танилцуулж, гэрээлэгчдээр мөрдүүлж ажилладаг. Компанийн журмын дагуу өрсөлдөхүйц үнийн санал авч, улмаар үнийн харьцуулалт хийх нь худалдан авалтын үйл ажиллагааны нэг чухал хэсэг ба нийцлийн үнэлгээг хийсний дараа нийлүүлэгчийг бодит шалгуурын дагуу шударгаар сонгон шалгаруулдаг.
- **Ханган нийлүүлэлтийн олон талт байдал:** Бадрах Энержи компани нь нийлүүлэгчидтэйгээ харилцан хүндлэл, итгэлцэл, бүтээлч харилцаа ба хамтын хүчин чармайлтын зарчимд тургуурлан олон улсын стандарт, журмын нийцлийг хангасан урт хугацааны хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар Монгол улсын эдийн засагт хувь нэмрээ оруулахыг эрмэлзэж ажилладаг.
- **Байгаль орчинд ээлтэй:** Байгаль орчныг хамгаалах ба болзошгүй нөлөөллийг бууруулахад хог хаягдлыг ангилан ялгаснаар хог хаягдлын менежментийг хийхээс гадна байгаль орчинд шууд нөлөөлж болохуйц бүх төрлийн ажилд нийлүүлэгчдийн гэрээнд тогтвортой хөгжлийн амлалтыг хавсаргадаг.



## Монгол улсын ханган нийлүүлэгчдийг дэмжин ажиллаж байна

Бадрах Энержи компани гадаад, дотоод сургалт зохион байгуулж, сайн туршлага хуваалцахаас гадна группийн мэргэжилтнүүдээр ханган нийлүүлэгчдийнхээ ажилд туслуулах зэргээр аюулгүй байдал, чанар, тогтвортой байдал, ил тод байдлын стандартуудаа сайжруулахад нь нийлүүлэгчиддээ дэмжлэх үзүүлж, урт хугацаанд, нээлттэй хамтран ажиллаж байна.

Орано группийн бусад салбар компанийн нэгэн адил Бадрах Энержи ХХК нь худалдан авалтын үйл ажиллагаандаа ёс зүй, хууль журмын нийцлийг хангах зарчмыг чанд баримталж аливаа төрлийн авлига болон / эсвэл ашиг сонирхлын нөлөөлд автахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Бадрах Энержи компанийн хангамжийн ажилтнууд Орано группийн Хууль дүрмийн нийцэл, Эдийн засгийн хяналтын албатай хамтран гуравдагч талыг шалгадаг.

Сүүлийн 4 жилийн үзүүлэлтээр Бадрах Энержи компанийн худалдан авсан бараа, ажил үйлчилгээний **95–97 хувийг Монгол улсын ханган нийлүүлэгчид эзэлж байна**. Ингэхдээ компанийн үйл ажиллагаа явуулж буй Дорноговь аймгаас хийсэн худалдан авалтын хэмжээ аажмаар өссөн үзүүлэлттэй байна (2017 онд 12 хувь байсан бол 2020 онд 18 хувь болсон).

Бадрах Энержи компани ханган нийлүүлэлтээ дийлэнхидээ Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдээс хийдэг бөгөөд ингэхдээ Монгол улсын аж үйлдвэрийн хөгжилд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.



(\*): Хамаарал бүхий талуудын гүйлгээ ороогүй.

# КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

Энэхүү нийгмийн хариуцлагын тайланг Бадрах Энержи ХХК-ийн төслийн бүх оролцогч талуудад компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх зорилгоор бэлтгэв.

Тус тайланд 2017 оны 1 дүгээр сарын 1–нээс 2020 оны 12 дугаар сарын 31–ний хугацаанд хэрэгжүүлсэн компанийн үйл ажиллагааны үр дүнг тусгав. Өмнөх тайлан 2015 онд хэвлэгдсэн билээ.

Бадрах Энержи ХХК нь үйл ажиллагаагаа аль болох ил тод, нээлттэй мэдээлэхийг эрмэлздэгийн хувьд компанийн нийгмийн хариуцлагын тайланг сэдэв тус бүрийн ач холбогдлын эрэмбэ, тэдгээрийн дүгнэлтэд суурилан боловсрууллаа.

Тайланд компанийн үнэ цэнийг бүтээх, мөн төслийн оролцогч талуудын шийдвэр гаргалтад ач холбогдол бүхий сэдвүүдийг багтаасан. Эдгээрт гарсан дүгнэлт нь Бадрах Энержи компанид бизнесийнх нь үйл явц дахь тогтвортой хөгжлийн олон хүчин зүйлсийг харгалзах, улмаар ажлаа оновчтой зохион байгуулж компанийн үнэ цэнийг бүтээхэд тусалдаг.

Сэдвийн сонголтыг дараах байдлаар хийв.  
Үүнд:

- **АЛХАМ 1:** Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол бүхий өргөн хүрээний сэдвийг тодорхойлсон.
- **АЛХАМ 2:** Эдийн засгийн нөхцөл байдал, байгаль орчин болон нийгмийн нөлөөллийг үнэлэх зорилгоор тухайн сэдвийн талаар хэлтсийн менежер, ажилтнуудтай ярилцсан.
- **АЛХАМ 3:** Оролцогч талуудын хүлээлт ба компанийн үйл ажиллагааны зарим хүчин зүйлээс тэдэнд үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох зорилгоор ярилцлага хийсэн. Тус судалгаанд ажилтан, хувьцаа эзэмшигчдээс эхлээд ханган нийлүүлэгчид, түнш, төрийн байгууллага, орон нутгийн болон олон улсын ТББ-ууд болон орон нутгийн төлөөлөл зэрэг компанийн үйл ажиллагаанд шууд оролцогч талуудыг хамруулсан.

Бадрах Энержи ХХК

2021 оны 9 дүгээр сар

Зураг чимэглэл: © Орано / Фредерик Ожэ, Аманкулов Жанарбек Аман - © Бадрах Энержи / Б.Буянхишиг, Г.Наранбаатар, Т.Бэлгүүн болон бусад - © Shutterstock / Denis Burdin, kaikup, linegold  
Тайлангийн дизайн: BLEU CERISE

<http://www.badrakhenergy.com>  
<http://www.facebook.com/badrakhenergy>



**Бадрах Энержи ХХК**

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,  
Жамьян гүний гудамж-9, ИСС цамхаг, 8-р давхар  
Утас: 7011 0475